

**СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-28
<i>1.Иргэний бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох</i>	3-28

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны
04 дүгээр сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 4 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 21 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд үг хэлэв.

Нэг.Иргэний бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Нарийн бичгийн дарга Д.Даваа-Очир, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт П.Алтанчимэг, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Э.Энхтуяа, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, мөн яамны Консулын газрын захирал Б.Болд, Төрийн захиргааны удирдлагын газрын захирал С.Золжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, мөн газрын Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын дарга Т.Гантөмөр, Иргэний бүртгэлийн газрын дарга Н.Наранцэцэг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Батсайхан, мөн газрын Кадастрын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Энх-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Иргэний бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Гадаад харилцааны яамны Төрийн захиргааны удирдлагын газрын захирал С.Золжаргал, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн нар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, Ц.Туваан нарын тавьсан асуултад Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Иргэний бүртгэлийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлын талаар холбогдох байгууллагуудын мэдээлэл сонслоо.

Уг асуудлыг 16 цаг 01 минутад хэлэлцэж дуусав.

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 40 минут үргэлжилж, 4 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 16 цаг 01 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ,
БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
14 цаг 21 минут.

СОНГОГЧИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ, БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Ганболд: Дэд хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгаж байна. Өнөөдрийн хуралдаанд 5 гишүүнээс 3 гишүүн ирж, ирц бүрдсэн тул дэд хорооны хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн дэд хорооны хурлаар иргэний бүртгэлийн өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлын талаар холбогдох байгууллагуудын мэдээллийг сонсох энэ асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн. Өнөөдрийн хуралдаанд бас Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Энхболд дарга бас оролцож байгаа. Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад гишүүд байхгүй болохоор, дуудчих уу? Тийм. Тэгээд хэлэлцэх асуудалтай холбогдуулаад асуух асуулт, саналтай гишүүн байна уу? Байхгүй болбол мэдээллээ, Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Хуралдаанд оролцож байгаа та бүхний энэ өдрийн мэндийг эрье. ТББХ-ны хүрээнд энэ бүртгэлийн асуудал хариуцсан дэд хороо албан ёсоор байгуулагдаад, үйл ажиллагаа явуулж байгаа. Ерөнхий зорилтуудынх нь талаар бол та бүхэн мэднэ. Тэр талаар би 1 их олон юм яриад яах вэ. Энэ удаа дэд хорооны хийх ажлын бас 1 чухал дотроо бодолцох зүйл нь нөгөө сонгуультай холбоотой асуудлууд байгаа юм. Өнөөдөр Улсын Их Хурлын даргад даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс боловсруулсан Сонгуулийн хуулийн төслийг өргөн мэдүүлсэн.

Хоёрдугаарт АН-ын зүгээс бас өөрсдийнхөө боловсруулсан хувилбар гээд бас 1 хуулийн төсөл өргөн мэдүүлсэн байгаа. Энэ 2 хуулийг хамтатгаад хэлэлцэх байх Улсын Их Хурал. Ингээд сонгууль болохоос 1 жилийн өмнө Сонгуулийн хуулийг цэгцэлсэн байх хуультай учраас бид ямар ч байсан хэлэлцэж байгаад 6 сарын 20-ноос өмнө одоогоор тооцоолж байгаагаараа бол энэ хуулиа хэлэлцээд батлаад явах ийм зорилттой ажиллаж байгаа. Сонгуулийн хуульд бол хэд хэдэн зарчмын саналууд орчихсон явж байгаа. Нэгдүгээрт холимог системээр явна. Пропорциональ, мажоритар 2 холиод, ажлын хэсгээс оруулсан хуулийн төсөлд бол нийт гишүүдийн 50% нь жагсаалтаар, 50% нь тойргоосоо гэсэн зохицуулалттай. АН-ынхнаас өргөн мэдүүлснээр надад одоогоор ирсэн мэдээгээр би эх хувийг нь хараагүй байна 28, 48 гэж байвал яасан юм гэсэн санал оруулж байгаа юм байна лээ. Ингээд энэ хоёрыг нэгтгээд явна. Ямар ч байсан холимог тогтолцоо дээрээ бол санал нийлчихсэн байгаа. Доторх харьцааны хувьд бол энийг хэлэлцүүлгийн явцад тохироод тэгээд эцэслээд батлах байх.

Тэгээд энэтэй холбогдоод энэ иргэдийн бүртгэлийн асуудал их чухал ач холбогдолтой болж байгаа. Иргэдийн бүртгэл, сонгогчдын бүртгэлийн асуудал. Ер нь сонгууль болгоноор маргаан дагуулдаг байсан. Хамгийн сүүлийн сонгуулиудаар хүртэл ер нь давхар хаяг, элдэв янзын юм гээд л сүүлд нь сонгуулийн үр дүнд нөлөөлчих вий дээ гэж санаа зовохуйцаар тийм зүйлүүд нь бол нэлээн их гарч байсан. Мэдээж энэ шинээр Сонгуулийн хууль батлаад явахаар улс төрийн их олон хүчнүүд намууд идэвх нь сэргэж, оролцож энэ бүртгэлийн асуудалд онцгой их анхаарал тавьж байгаа. Тэр ч байтугай энэ манай дэд хороог хүртэл сөрөг хүчнээс удирдлагатай байх ёстой энэ тэр гэсэн ийм саналууд явж байгаа юм билээ.

Тэгэхээр би нэг их олон дэд хороо юм уу эсхүл сонгуультай холбогдсон бүтэц бий болж хэрэггүй болов уу гэж бодож байгаа. Угаасаа энэ дэд хороо сонгуулийн үед ч, сонгуулийн бус үед ч иргэдийн бүртгэл жагсаалтын алдаа дутагдалгүй байдал, бүрэн бүтэн байдал, давхардал, элдэв дутагдал юм байхгүй энэ талыг нь хийгээд явах ийм зорилттой Байнгын хорооны дотроос байгуулагдсан дэд хороо учраас энэ дээрээ ажил нь төвлөрөөд явах нь зүйтэй байх гэж би бол хувь хүний хувьд ингэж бодож байна.

Тэгэхээр маш их хариуцлагатай ажил болно. Төрийн сонгууль эцсийн үр дүн нь хүлээн зөвшөөрөгдөхгүй юу, үгүй юу гэдгийг шийдэхэд бол 1 чухал хүчин зүйл болж орох учраас манай дэд хороо, ажлын дэд хэсэг та бүхэн маань энэ ажилд их хариуцлагатай хандаарай. Одоо ямар зүйлүүд байна. Бушуухан ойрын хугацаанд янзалж авах зүйлүүд нь юу байна. Цаг хугацаа авах зүйлүүд юу байна. Тэгвэл Их Хурлын зүгээс Засгийн газраас юу хийх вэ.../минут дуусав/

Г.Ганболд: Энхболд гишүүний микрофоныг сунгаж өгье, цаг нэмээд өгчих.

Н.Энхболд: Энэ дээр их анхаарлаа хандуулж ажиллаарай. Гадаадад сууж байгаа, ажиллаж амьдарч байгаа иргэдийг оруулах боломж нь нэлээн өргөн хүрээтэй оруулах боломж бол энэ удаа бас нээгдэж байгаа. Энэний түрүүчийн сонгуулиудаар гадаадад байгаа 200-гаад мянган иргэн гэж ярьдаг. Тэрэн дотор тэгээд хүүхэд элдэв улсууд байдаг л биз. Тэр хүмүүсээс 5000 орчим нь сонгуульд саналаа өгнө гэж бүртгүүлчхээд, тэгээд өгсөн нь бол 4000 гаруй л байдаг юм байна лээ. Тэгээд энийг их бага гэж үздэг. Зохион байгуулалттайгаар энийг бага байлгаж байна гэж улс төрийн намуудын зүгээс бас шүүмжилдэг.

Тийм учраас гадаадад байгаа иргэдийн бүртгэл тэр юмнуудыг ЭСЯ, дипломат төлөөлөгчдийн газруудтай

уялдуулж тодотгох сүүлд нь маргаангүй байх хэмжээнд гаргах энэ асуудал дээр бас 1 онцгой анхаарах хэрэгтэй байна манай дэд хорооны гишүүд. Тэгээд дахиад хэлэхэд. Тэгээд эцсийн дүндээ бол энэ асуудлууд ТББХ-н дээр орж ирнэ. Ямар 1 байдлаар яригдана, шийдэгдэх юмнууд байвал бид нар бүгдээрээ хамтраад шийднэ. Ер нь үлдэж байгаа 1 жилийн хугацаанд манай бүртгэлийн байгууллага, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс хамгийн их анхаарал тавих асуудлуудын 1 нь энэ болж байгаа учраас та нар ер нь угаасаа энэ бүртгэлийн асуудлыг тэртээ тэргүй хариуцах ёстой дэд хороо ч гэсэн сонгуулийн асуудалд онцгой анхаарал тавьж, одоо ингээд бас Ганболд даргад бид нар өргөн барьсан 2 хуулийн төслийг танд өгчихнө.

Тэгэхээр та тэрэн дотроос яг тэр бүртгэлтэй холбоотой заалтууд нь юу байна, тэрэн дээрээ онцгой анхаарал тавьж, цэгцлэх юмнуудаа яриарай. Сая хүүхдийн мөнгө өгөхөд бөөн маргаан гарсан шүү дээ, тийм ээ. Энэ юунаас болсон, тэрийгээ арилгах хэрэгтэй байна. Өөрөө мэдэлгүй олон хүүхэдтэй болчихсон хүмүүс гарч ирсэн, тэр бүртгэлээсээ болоод. Хүүхэдгүй болчихсон хүмүүсийн тухай мэдээлэл гарч ирсэн. Энүүнийг ашиглаад, ашиглаад ч юу байх вэ, үнэхээр тийм зөрүүтэй мэдээ гарч байгаа бол тэртээ тэргүй иргэдийн зүгээс, нийгмийн зүгээс бухимдал гаргах, хардах, сэрдэх зохион байгуулалттай хийж байна гэж бодох ийм юм тэртээ тэргүй автоматаар гарна. Тэгэхээр энэ зүйлүүд дээр онцгой анхаарч ажиллаарай гэж би та бүхэндээ хэлэх гэж байгаа юм.

Ерөнхийдөө бол манай Байнгын хорооны дарга бас Мөнхбат гишүүн энэ байнгын хорооны бүрэлдэхүүнд уг нь дэд хорооны бүрэлдэхүүнд өөрөө байсан тийм ээ. Тэгээд шаардлагатай бол одоогоор бол би байхгүй. Тэгэхдээ Байнгын хорооны даргын хувьд энэ дээр саналаа хэлье гэж бодсон юм. Шаардлагатай гэж үзвэл тэрэн дээрээ тогтоол оруулж байгаад

нэмээд орчихсон ч болох л байх. Тэнд болохгүй юм байхгүй. Энэ зүйлүүдийг сайн анхаараарай л гэж хэлэх гэсэн юм.

Г.Ганболд: Энхболд даргад баярлалаа. Тэгээд өнөөдрийн хурлын гол зорилгыг бол та бүхэн ойлголоо. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль орж ирсэнтэй холбогдуулаад 3 асуудал өнөөдөр ярих гээд байна шүү дээ. Нэгдүгээрт нь, гадаадад байгаа иргэдийн саналыг авбал ямар хэмжээний зардал орох юм, хэдий хэмжээний хүмүүс орох юм, энэ хүрээндээ тэр хүмүүс зөвхөн пропорциональ дээр нь холимог тогтолцоо батлагдах юм бол тэр рүү орох уу гэдэг асуудлыг нэгдүгээрт бид нар урьдчилж тооцох ёстой. Хууль батлагдсаны дараа баахан зардал орж ирдэг, тэрийгээ баталж чадахгүй явах тохиолдлууд зөндөө байгаа учраас энийг ярих нь.

Хоёрт нь болбол нөгөө сонгууль болгоны дараа л нэг царцааны тухай асуудал ярьдаг. Энэ асуудлаа Сонгуулийн хуулиас зэрэгцүүлээд энийгээ ярих нь зүйтэй. Энэ нь эргээд нөгөө сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх, ялагдсан бүх хүмүүст 1 тийм гомдол тээдэг 1 ийм юмнууд жил болгоны сонгууль дээр явдаг учраас энийгээ ер нь бол шилжилт хөдөлгөөнөө яаж зохицуулах юм гэдгийгээ 1 Сонгуулийн хуультайгаа цуг явуулах нь зүйтэй.

Гуравдугаарт нь, ерөөсөө хаягжилтын асуудал. Сая Энхболд дарга хэллээ. Сая хүүхдийн мөнгөтэй холбоотой нөгөө сонгуулийн үеэр баахан шилжилт хөдөлгөөн хийчихсэн. Тэрнээсээ болоод нөгөөдөх нь нөгөө хүүхдийн мөнгөнд нь нөлөөлдөг. Сонгууль өгөхийн тулд өөр айлын хаяг дээр очоод бүртгүүлчихсэн байсан чинь нөгөөдөх нь эргээд нөгөө айлууддаа гай болж байгаа юм зөндөө гарч байна шүү дээ. Тэгээд энийг ер нь бол ингээд цэгцэлье гэдэг байдлаар энэ түр хорооны хурлыг зохион байгуулж, ер нь мэдээлэл сонсож энэ хүрээнд ер нь ямархуу зардал гарах юм, энэ юуг шийдэх

юм гэдгийгээ 1 урьдчилж хараад, энийгээ Сонгуулийн хуультайгаа цуг явуулъя гэдэг ийм зорилгоор өнөөдөр өнөөдрийн дэд хорооны хурлыг зохион байгуулж байгаа юм. Ингээд өнөөдрийн хуралд оролцож байгаа би, асуудлаа ингээд хэлэлцье. Нэгэнт гишүүд асуудал хэлэлцэх асуудалтай холбогдуулж үг хэлээгүй учраас.

Өнөөдрийн хуралд Дэлгэрнарэн Сонгуулийн ерөнхий хорооны дарга, Даваа-Очир Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга, Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга, Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Магнайсүрэн БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Анхбаяр Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Дэлгэрсайхан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Болд Гадаад хэргийн яамны Консулын газрын дарга, Золжаргал Гадаад хэргийн яамны Төрийн захиргаа удирдлагын газрын дарга, Энхтуяа Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Гантөмөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бодлого, төлөвлөлт, дүн шинжилгээний газрын дарга, Ууганцэцэг СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт, Алтанчимэг СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн ахлах референт, Наранцэцэг Улсын бүртгэлийн ерөнхий газрын иргэний Улсын бүртгэлийн газрын дарга, Батсайхан Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын үүрэг гүйцэтгэгч, Энх-Эрдэнэ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн даргын албан үүрэг түр орлон гүйцэтгэгч гэсэн ийм хүмүүс ажлын оролцож байна.

Ингээд хэлэлцэх асуудлын дарааллын дагуу Иргэний бүртгэлийн өнөөгийн байдал тулгамдаж буй асуудлын талаар УБЕГ-ын дарга Дэлгэрсайханы мэдээллийг сонсьё, мэдээллээ. Дэлгэрсайханы микрофон хэд

байна, хэдэн номер байна вэ? Дэлгэрсайхан чи ажлын хэсгийн 2 номер дээр суучих. Ажлын хэсгийн 2 номер.

Д.Дэлгэрсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. УБЕГ-ын дарга Дэлгэрсайхан мэдээлэл хүргэж байна. Би улсын бүртгэлийн байгууллагын өнөөгийн байдлыг энэ Сонгуулийн хуулиар хүлээсэн үүрэг, хэрэгжилттэй холбоотойгоор товч мэдээллийг хүргэх гэсэн юм. Ингээд явбал болох юм шиг байна.

Өнөөдөр улсын бүртгэлийн байгууллага 3.4 сая иргэн, 1.1 сая үл хөдлөх, 218 хуулийн этгээд, ялангуяа энэ 150 сая цаасан эх нотлох баримт 110 тера бит хэмжээтэй ийм өгөгдөл дээр ажилладаг ийм томоохон байгууллага байна. Манай байгууллага дээр 42 төрлийн программ хангамжийн системүүд, 37 төрлийн мэдээллийн сан, яг сонгуульд хэрэглэгддэг 2100 гаруй offline энэ файлын санг хэрэглэдэг ийм байгууллага болж хөгжсөөд явж байна. Ер нь улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбоотой 6 чухал зүйл байгаа. Энийг би энэ мэдээлэл дээрээ бас танилцуулъя гэж бодсон юм.

Эрх зүйн орчин гэж 1. Бид нар 2018-нд Улсын бүртгэлийн багц хууль батлагдсан. Багц хуультай холбоотойгоор бүртгэлийн ангиллыг, бүртгэлийг хэрхэн цахимаар хөтлөх юм, ялангуяа мэдээллийг хэнд өгөх юм, энэ мэдээллийн сангуудын хоорондын уялдаа холбоо ямар байх юм, нууцлалт хамгаалалтын асуудлууд гэж нэлээн ийм чухал асуудлууд энэ багц хуульд бол орсон байдаг юм.

2-т нь энэ программ хангамжийн асуудал байж байгаа. Яг өнөөдрийн байдлаар бид нар иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд нэмэх нь яг үндсэн 3 чиглэлээс гадна энэ архивын мэдээллийн санг удирддаг, хадгалдаг, хамгаалдаг, боловсруулдаг ийм программ хангамжийг 2016 оноос хойш өнөөдрийг хүртэл хөгжүүлсэн. Өөрөөр хэлбэл бид нарын

хэрэглэж байгаа программ яг түрүүчийн хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс зохион зохиож бүтээгдсэн ийм системүүдээр бид нар ажиллаж байна. Тоног төхөөрөмж, техник хангамжийн хувьд бид нар саяхан л 2016 онд зөвхөн 33 хороо холбогддог байсан бол өнөөдөр 172 хороо, 330 сум, бүх аймгууд, нийслэл нийслэлийн үйлчилгээний төвүүд нэгдсэн ийм сүлжээнд холбогдож ажиллаж байна.

Хамгийн сүүлийн жишээгээр хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газрын Консулын 5 консулын газрыг бид нар VPN сүлжээнд холбоод ажиллаж байна. Мэдээллийн сангийн хувьд бол би тэр иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, дээрээс нь энэ сонгуулийн мэдээллийн сантай холбоотойгоор нэгдсэн ийм санг хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл бид нарын аль ч нэгж, аль ч хороо, аль ч үйлчилгээний нэгдсэн цэг дээрээс бид нар зөвхөн нэгдсэн 1 санг ашигладаг ийм онцлог байгаа. Бусад байгууллагатай холбогдох үүднээс бид нар саяын дурддаг иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн мэдээллийг бусад байгууллагуудад ашиглуулдаг. Өөрөөр хэлбэл бид нар зөвхөн улсын бүртгэл бол суурь мэдээллээ бас хадгалаад хамгаалаад явдаггүй. Өнөөдөр бид нар 2022 оны статистикаар зөвхөн төрийн байгууллагуудад 200 сая гаруй мэдээллийг хэрэглүүлсэн ийм статистик байна.

Цахимжуулалт эх нотлох баримтыг бол бид нар сонгуулийн үед ч юм уу сая бас дурдлаа. Энэ шилжилт хөдөлгөөн ч байдаг юм уу, аль ч газраас нь бид нар энэ шилжилт хөдөлгөөний мэдээллийг эх нотлох баримттай нь шууд танилцах ийм боломжтойгоор өнөөдөр үйл ажиллагаагаа явуулж байна. Энэ үйлчилгээний шинэчлэлтэй холбоотойгоор ялангуяа энэ сонгуультай холбоод ярихлаар их хэд хэдэн чухал зүйл бид нар хийгээд хэрэгжилтийг хангаад явж байна. Тодруулбал энэ харьяалал харгалзахгүй үйлчилгээ. Өмнө нь зөвхөн Хэнтий аймаг гэдэг юм уу, Дорнод гэдэг юм уу, Увс аймагт харьяалалтай хүн

зөвхөн тэндээсээ үйлчилгээгээ авдаг. Тэндээ иргэний үнэмлэх байдаг юм уу, бусад үйлчилгээгээ жишээ нь захиалдаг байсан бол өнөөдөр аль ч нэгж дээрээс харьяалал харгалзахгүй үйлчилгээг нэгдүгээрт авч болж байна.

Хоёрт онцолж хэлж байгаа зүйл бол энэ шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бид нар нэлээн боловсронгуй болгоод ажиллаж байна. Тодруулбал өмнө нь 1 газраасаа хасалт хийгээд, нөгөө газраа очиж бүртгүүлдэг байсан. Хасалтаа хийлгэчихээд бүртгүүлээгүй иргэдийн хувьд бол бас дунд нь энэ хаяггүй, энэ хаягийн зөрчилтэй үлдэх ийм асуудлууд байдаг байсан. Одоо бол зөвхөн 1 талдаа бид нар бүртгүүлээд, нөгөө талаасаа систем дээрээс автоматаар хасдаг ийм зохицуулалт хийснээрээ дунд нь иргэд ямар нэгэн байдлаар хоцорч үлдэхгүй ийм зохион байгуулалттайгаар бас ажиллаж байгаа. Нэлээн олон байгуулагатай бид нар энэ дундын мэдээллийн санг ашиглаж байна. Тодруулбал Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартайгаар энэ газрын бүртгэлтэй холбоотойгоор бид нар дундын мэдээллийн санг ашигласнаараа зөвхөн улсын бүртгэл суурь бүртгэл биш бас бусад энэ суурь бүртгэлийг дундаа хэрэглэх ийм боломжоор бас бид нар хангагдсан.

Иргэдийн хувьд төр өөрт байгаа мэдээллээ иргэдээс нэхэхгүй гэдэг энэ зарчмаар одоо иргэд өөрсдийнхөө мэдээлэлтэй танилцах боломжоор бол бүрэн хангагдсан байгаа. Тодруулбал миний дараагийн слайд дээр гарна. ИМонгол систем дээр бид нар 90 гаруй үйлчилгээг цахимжуулсан. Тэгэхээр өнөөдөр иргэд өөрийнхөө хаягийн байдаг юм уу, бусад энэ иргэний улсын бүртгэл, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээллээр цахим орчинд дээрээс нь биеэрээ байдаг юм уу танилцах энэ бололцоогоор бүрэн хангагдсан байдаг юм. Би 2 зүйлийг бас энд онцолчихъё.

Яг өнөөдрийн байдлаар бид нар энэ регистрийн дугаар, энэ хаяг, тоон гарын үсэг гэх мэтчилэн зүйлүүдийг хэрэглэж байна. Мөн регистрийн дугаар дээр бас асуудлууд нэлээн энэ түүхэн цаг үед бол нэлээн яригддаг байсан. 1988 онд энэ ХААТР гээд хүн амын автоматжуулсан төв регистр гэдгийг байгуулснаас хойш өнөөдөр бид нар регистрийн дугаарыг хэрэглээд ирсэн. Яг өнөөдөр хэрэглээнд бид нар түлхүү, бүртгэлийн дугаарыг оруулж байгаа юм. Яагаад гэвэл энэ регистрийн дугаар гэдэг бол өөрөө бас тодорхой хуулиараа бас өөрчлөгдөж болохуйц зүйл байдаг. Өнөөдөр жишээ нь хүйс сольсны бүртгэл гэж хийгдэж байна, бас хийгдчихсэн байгаа. Тэгэхээр иргэн хүйсээ сольсон тохиолдолд регистрийн дугаар дагаад солигддог. Шүүхээр насаа тогтоолгох тохиолдлууд байдаг. Энэ тохиолдолд бас регистрийн дугаар солигдох. Өөрөөр хэлбэл бид нар яг өнөөдрийн түүхэн хөгжилдөө регистрийн дугаар бол давтагдахгүй өгөгдөл гэдгийг бас илэрхийлж чадахгүй байж байгаа учраас бид нар өнөөдөр нэлээн олон байгууллагууд дээр манай сан дээр иргэн төрмөгц бүртгэлийн дугаарыг олгож байгаа. Өмнө нь бол хэдэн жилийн өмнө 16 нас хүрэхээр бүртгэлийн дугаар олгодог байсан бол одоо төрмөгц олгож байгаа. Иргэн хэзээ ч өөрчлөгдөхгүй, солигдохгүй, давтагдахгүй ийм 12 оронтой бүртгэлийн дугаарыг бас хэрэглэж байгаа ийм онцлог бас байгаа.

Мөн цахимжилт бас нэлээн чухал асуудал учраас иргэнийг цахим орчинд таних үүднээс тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлсэн. Энэ 3 сарын 27-ны байдлаар 602746 тоон гарын үсгийг улсын бүртгэлийн байгууллагаас олгоод байна. Ер нь 4 үйлчилгээнээс бусад нь манайх бол цахимжсан гэж бас ойлгож болно. Биеийн давхцахгүй өгөгдөл, гэрлэлт, харьяат болсон, харьяатаас гарсан, харьяат сэргээсэн, хоригтой холбоотой гэж. Цахимжилт гээд ганцхан зүйл хэлчихье. Энэ дээр бид нар яг өнөөдөр би түрүүн хэлсэн. Яг өнөөдрийн байдлаар бид нар 2.5 сая энэ үйлчилгээг иргэддээ

бас цахимаар үзүүлчихсэн байж байгаа. Энэний цаана бас энэ сонгуультай холбоод хэлэхэд иргэд энэ хэмжээгээр өөрийнхөө мэдээлэлтэй цахим орчинд танилцах бас бололцоогоор хангагдаад явж байна гэж бас ойлгож болно.

Миний 2-т ярих гэж байгаа гол зүйл бол яг өнөөдөр энэ сонгуулийн Улсын бүртгэлийн байгууллага Сонгуулийн хуулиар хүлээсэн үүрэг үүн дээр ямар зүйл тулгамдсан ямар асуудал байгаа юм бэ гэдгийг товчхон ярьчихъя. Бид нар яг өнөөдөр 2012 оноос хойш нийтдээ 21 сонгуулийг яг шинэчилсэн бүртгэл бий болгосноос хойш буюу яг энэ автоматжуулсан системийг хэрэглээд явуулаад иржээ. Энэ дээр ээлжит сонгууль нь 9 удаа болсон байна. 2012, 16, 20 онд Улсын Их Хурал болоод аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, 13, 17, 21 онд нь Ерөнхийлөгчийн ээлжит сонгууль гээд зөвхөн ээлжит сонгуулийн хувьд бол бид нар 9 удаагийн сонгуулийг явуулжээ.

Сонгууль явуулахдаа энэ улсын бүртгэлийн байгууллагын хамгийн чухал асуудал юу байдаг вэ гэхээрээ мэдээж сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах, хүргүүлэхтэй холбоотой асуудал байдаг. Энэ дээр бид нар үндсэндээ улсын бүртгэлийн байгууллагын ажил 1 сараас төлөвлөгөө гараад ажиллаад эхэлдэг. Энд ойролцоогоор 75-95 ажилбар өгөх ийм төлөвлөгөө гаргаад, батлаад ажилладаг юм байгаа юм. Сонгуулийн тов, ажлын хэсэг энэ цаг хугацааны хуваарь гардаг. Мэдээж холбогдох хууль журмууд гардаг. Энэ журмууд дээр үндэслээд ажилладаг гэсэн үг.

Миний өнөөдөр ярих гэж байгаа асуудлын нэлээн чухал хэсэг нь бол энэ дэлгэц дээр гарч байгаа. Өөрөөр хэлбэл бид нар сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх танилцуулга хүргүүлэхдээ дараах ийм олон процессыг бас дамждаг юм. Өөрөөр хэлбэл сонгуулийн нэрийн жагсаалтыг гаргахдаа улсын бүртгэлийн

байгууллага биш, харин аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ хэсэг байгуулахаас манай асуудал эхэлдэг. Өөрөөр хэлбэл бид нар тухайн хэсэг байгуулахдаа сонгогчдын тухайн хэсэг дээр хэчнээн тоо байх юм, тоогоо өгөөд, ажил маань эхэлдэг. Тухайн тоонд үндэслээд хэсгүүд байгуулдаг. Тухайн хэсэг дэх сонгогчдын нэрийн жагсаалтыг бид бүхэн үйлдэж танилцуулах, хүргүүлэх ажлаа эхлээд явдаг юм байгаа юм.

Эхлээд хэдхэн гол зүйлийг дурдчихъя. Сонгогчдын эцэг эхийн нэр, өөрийн нэр, хүйс, нас хүйс, регистр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг гэх мэтчилэн ийм мэдээлэл бүхий нэрийн жагсаалтыг гаргадаг. Энэ дотор процесс болгон дээрээ нягтлан шалгах үйлдлүүд их хийгддэг. Иргэддээ хамгийн түрүүн 4 сарын 1-ний өдөр өдрөөс эхлээд өөрийн цахим хуудсан дээрээ байршуулж, танилцуулах нэрийн жагсаалтыг танилцуулах энэ ажиллагаа маань эхэлдэг. Сүүлийн сонгуулиуд буюу Ерөнхийлөгчийн сонгууль байж байна. Энэ сонгуулиудад илүү иргэд мэдээлэлтэйгээ танилцах энэ боломжоор бас бид нар хангасан байгаа. Тодруулбал тухайн иргэн өөрийнхөө хаяг дээр оршин сууж суугаа бусад хүмүүсийн мэдээлэлтэйгээ бас танилцдаг болсон. Энэтэй холбоотой зөрчил, ямар нэгэн зүйл бол улсын бүртгэлийн байгууллагад бас хандаж энэ асуудлаа шийдүүлэх, шалгуулах ийм бололцоогоор бас хангагдсан байдаг. Энэ ажил маань ерөнхийдөө 4 сарын 1-нээс бол нэлээн эрчимтэй эхлээд явдаг гэх гэсэн үг.

Дараа нь энэ Дээд шүүх, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Иргэн, Батлан хамгаалан яам, гэх Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гэх мэтчилэн 6 байгууллагатайгаа мэдээллийг солилцож, хасав түр хасах тэмдэглэгээг тавьдаг. Өөрөөр хэлбэл сонгуулийн нэрийн жагсаалтыг ирdate хийж өөрчлөх үндсэн гол энэ гол байгууллагуудтайгаа хамтарч ажилладаг. Сүүлийн бас жишээнүүдээс

харж байхад энэ дээр бас ТББ буюу холбогдох байгууллагаар бид нар сонгууль, сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэж байгаа энэ процессыг бас хянуулдаг болсон байгаа. Энэ бол бас нэлээн онцлог. Өөрөөр хэлбэл яг яаж үндсэн сан бааз үүсгэж байна, энэ дээрээ давхардлыг хэр шалгаж байна вэ, ялгаж байна гэдэг дээр ажлын хэсгийн бүр ингэж дүгнэлт гаргаж бид нар ажилладаг.

Үүний дараагаар бид нар мөн нягтлан шалгах, нягтлан шалгах гэдэг үгийг би яагаад энэ олон хэлээд байна вэ гэхээрээ энэ улсын бүртгэлийн байгууллагын миний түрүүний дээр дурддаг 330 сум, 172 хороо гэх мэтчилэн бүх нэгжээрээ энэ сонгуулийн нэрийн жагсаалтыг бас бий болгож, үйлдэж байгаа дээр нягтлан шалгах ажлууд хийгддэг. Мөн итгэмжлэгдсэн ажилтан бол бид нар ойролцоогоор 2500 итгэмжлэгдсэн ажилтан ингээд ажиллаад явдаг юм. Ингээд нягтлан шалгах ажлуудын дараа бас намуудад энэ мэдээллийг бас бид нар өгч байсан. Ингээд сонгуулийн өдөр улсын бүртгэлийн байгууллагаас хамгийн гол хийгддэг бас 1 ажил бол иргэдийг таньж баталгаажуулах ийм ажил байдаг. Энэ дээр бол улсын бүртгэлийн байгууллагатай гэрээ хийсэн, Тагнуулын ерөнхий газраар бас итгэмжлэгдсэн холбогдох гэрээ хийхэд зөвшөөрөгдсөн ийм хүмүүс ажиллаж, яг сонгуулийн өдөр сонгогчийг таньж баталгаажуулах энэ ажлыг бол хийдэг.

Ер нь зүгээр би сонгогчдын нэрийн жагсаалт гэдэг бол иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дээр үндэслэдэг боловч үндэслэдэг. Гэхдээ энэ бол тусдаа мэдээллийн сан үүсгэж ажилладаг. Тусдаа үүсгэхдээ энийг бол Тагнуулын ерөнхий газар болоод бусад газрууд түрүүн дээр дурдсан хянан шалгах ажлуудыг бас хийдэг юм. Давхардлыг арилгах гэдэг яг өнөөдрийг хүртэл хийсэн технологийн хувьд хамгийн сайн шийдэл бол энэ offline сангуудыг л үүсгэж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид

нар нэгдсэн том сангаасаа бүр хэсэг болгоноор нь offline санг үүсгээд, тэр сан дээр жишээ нь Дэлгэрсайхан бичигдлээ бол өөр сан дээр ингэж бичигдэх бололцоогүйгээр ингэж ийм зохион байгуулалтыг хийгээд, эргээд дараа нь бас нэгдсэн сангаа бас бид нар нэгтгэж бас шалгадаг ийм онцлогтой.

Г.Ганболд: Дэлгэрсайхан.

Д.Дэлгэрсайхан: Тэгээд би гол ганцхан асуудлаа хэлчихье тэгэх үү? Энэ дээр. Энэ л байж байгаа юм. Сая бас яригдлаа. Өнөөдөр хүртэл энэ техник технологийн хувьд шинэчлэгдээгүй буюу энэ баруун, зүүн дээд булан дээр харагдаж байгаа ийм багц байдаг юм. Энэ багц маань 2012 оноос хойш бол 1 ч шинэчлэгдээгүй явж байгаа. Энэнээс үүдээд хурууны хээгээр уншиж танигдах бололцоогүй, зарим үед принтер нь ажиллахгүй гацах гэдэг асуудлууд өнөөдөр нэлээн асуудал болоод явж байгаа. Би хаягийн асуудлыг мэдээж газар зохион байгуулалтууд ярих учраас би түрүүн хэлсэн энэ хүүхдийн мөнгө гээд бас 1 ийм асуудал ярьчихлаа.

Бид нар энэ хүүхдийн мөнгө байдаг юм уу, яг энэ дээр бол үндсэндээ хүүхдийн мөнгө бол өрхийн мэдээллийн сан дээр үндэслэж байсан. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сан дээр бол үндэслэгдэж бол гаргагдаж тооцогдоогүй юм байгаа юм. Яг энэтэй холбоотойгоор бид нар энэ дээд буланд харагдаж байгаа одоо манай энэ сайт дээр ч гэсэн байрласан байгаа. Өөрөөр хэлбэл бид нар иргэн өөрийнхөө хаяг дээр оршин сууж байгаа ямар хүмүүс байна гэдэгтэйгээ танилцах бололцоогоор хангачихсан. Яг өнөөдрийн бодит амьдрал дээр энэ 205583 иргэн өнөөдөр бол яг ороод шалгасан байна. Үүний 95 хувь нь би бол ямар нэгэн зөрчилгүй байна гэдэг байдлаар манай руу бол хандсан. Энэ мэдээлэл шалгуулах хүсэлтийг 9900 нь ингээд гаргасан юм байгаа юм. Энэ дотроос дахиад зөрчилгүй гээд үндсэндээ яг 1300-гаад хүн дээр бид нар шалгах

ажиллагаа явуулаад харилцан ажиллаад бас ингээд явж байна.

Хаяг дээр энэ миний хамгийн сүүлийн слайд. Өнөөдөр Монгол Улсад яг энэ газрын кадастр буюу нэгж талбарын дугаар дээр үндэслэсэн хаягийг бий болгох энэ асуудлууд хийгдэж байна. Гэтэл нөгөө тал дээр улсын бүртгэлийн байгууллага саяын ингээд 21 сонгууль үзчихсэн ийм хаягтай иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн хамгийн их хэрэглээг одоо хэрэглээг нь бид нар гаргаж байна. Энэ талаас хаягийн нэгдсэн сан бий болж байна. Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын энд баталсан том ажлын хэсэг ажиллаад явж байгаа. Энэ дээр бид нар энэ хаягийг нэгдсэн нэг сан бий болгох талаар бас ажиллаад явж байгаа юм. Энэ хаягийн асуудал бол мэдээж жил жилийн сонгууль дээр нэлээн асуудал болж яригддаг. Энэ удаагийн хувьд бол энэ хаяг нэлээн бас эрсдэлтэй байж магадгүй асуудал нь бид нар яг энэ цаг үед энэ хаягийн асуудлаа цэгцлэхгүй бол бас 1 иргэн шинэ болон хуучин хаяг гэдэг ийм 2 янзын хаягтай болбол энэ нэрийн жагсаалт бас буруу гарах ийм магадлал байгаа юм. Баярлалаа.

Г.Ганболд: Баярлалаа. Та хэд маань манай дэд хорооны нэрийг мэдэж байгаа тийм ээ? Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо. Энэ агуулгаараа бид нар байна шүү дээ нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналт гэдэг агуулгаараа биш та нар байна шүү дээ нөгөө түмэн зовлон ярихаас илүү өмнөх сонгуулиуд дээр гарсан зөрчлийн шууд кэйс яривал бүр сайн. Ийм зөрчил гараад, энэнийх нь араас явсан чинь хууль, эрх зүйн хувьд энийг шийдэх ёстой байсан. Энэнээс болоод юу гэдэг юм ялагдсан хүмүүс нь гомдол гаргасан. Энэнээс болоод юу гэдэг юм ийм зөрчил нь Сонгуулийн хороонд байсан юм уу, эсвэл нөгөө хаягжилт дээр байсан юм уу, Улсын бүртгэлийн хэлтэс дээр байсан юм уу. Тэгээд нөгөө царцаа гээд 1 юм яриад

байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг тэр өмнөх сонгуулиудын практик дээр түшиглэсэн ийм юмнууд яриад, энийг заавал ингээд шийдэх ёстой байна. Энийг бид нар ингээд шийдэж чадахгүйгээс болоод өмнөх сонгууль дээр ийм жишээ гараад, тэгээд энэ нь хуулиас болоод, тэгээд энэ нь сонгуулийн дүнд нөлөөлсөн ч гэдэг юм уу, нэг ийм юмнууд яриад шийдлээ ярихгүй бол зүгээр ингээд нэг түмэн зовлон тоочих юм бол энэ өөрөө гарцгүй юм болно л доо.

Бид нар өөрсдөө энэ Их Хуралд байгаа энэ түр хороонд байгаа энд сууж байгаа гишүүд бүгдээрээ тэр Сонгуулийн чинь хуулийг бараг зарим 1 юмыг нь бараг та хэдээс ч илүү мэдэж байгаа хүмүүс байгаа л даа. Тэгэхээр зэрэг энэ дээр илүү та хэд маань мэдээллээ бэлэн нэг иймэрхүү зөрчил гарсан. Тэгээд энийг заавал хуулиар энэ Сонгуулийн хуультайгаа цуг шийдэх ёстой гэдэг ийм шийдлүүд яривал илүү их сайн байна гэж хэлэх гэж байна. Дэлгэрсайхан даргад баярлалаа. Одоо Гадаад харилцааны яамны мэдээллийг Гадаад харилцааны яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга Золжаргал танилцуулна. Золжаргал 2 номер. 2 номерын микрофон өгье.

С.Золжаргал: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Гадаад харилцааны яамны хувьд гадаадад амьдарч байгаа Монгол иргэдийг сонгуульд оролцуулах ажлыг зохион байгуулах 5 нийтдээ 4 удаа зохион байгуулсан байдаг. Өнөөдөр 2020 оны эцсийн байдлаар Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газруудын тайлан мэдээллээр Монгол Улсын 176000 орчим гаруй иргэн гадаадын 90 орчим улсад оршин сууж байгаа гэсэн мэдээлэл байдаг. Үүнээс мэдээж хамгийн их нь БНСУ-д 52000 орчим иргэн, АНУ-д 30000, БНХАУ-д 17000 гаруй, Япон улсад 13000 орчим, Чех улсад 10000 гаруй, Швед улсад 8000 гаруй иргэн хамгийн олноороо оршин сууж байгаа нэгдүгээрт 7 улсад.

Мөн Австрали, Герман, Турк, Франц улсуудад тус бүр 5-аас 6000 орчим иргэн оршин сууж байгаа. ОХУ, Казахстанд нийтдээ 4000 орчим иргэн байгаа. Эдгээр иргэдийн хууль иргэдээс 125000 орчим нь бол хууль ёсоор албан ёсоор оршин сууж байгаа гэсэн мэдээлэл байгаа. Мөн үүнээс 0-16 насны хүүхэд нь 20000 орчим байгаа, оюутан нь 46000 орчим байгаа. Харин хууль бусаар 37000 гаруй иргэн оршин сууж байна гэсэн мэдээ байгаа. Гадаад харилцааны яамны хувьд 2012 оны Улсын Их Хурлын сонгуулийг гадаадад байгаа дипломат төлөөлөгчийн газрууддаа түшиглэн 39 салбар комисс байгуулан ажиллаж, энэ үеэр 4276 иргэн сонгогч иргэн оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн байдаг. Үүнээс санал хураалтад 2777 буюу 64.9 хувь нь оролцсон байдаг. Яг энэ сонгуулийн ажилд нийтдээ 241 сая төгрөг зарцуулсан байдаг.

2 дахь сонгууль нь 2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль байсан. 2013 оны Ерөнхийлөгчийн сонгуульд мөн 49 салбар комисс байгуулагдаж, 6233 иргэн оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн байдаг. Үүнээс санал хураалтад 4248 буюу 68.2 хувь нь саналаа өгсөн. Үүнд энэ 13 оны сонгууль нийтдээ 312 сая гаруй төгрөг зарцуулсан байдаг. 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулаагүй, хилийн чанадад зохион байгуулаагүй. Төв комиссыг СЕХ-ны тогтоолоор татан буулгасан байдаг. 2017 онд Ерөнхийлөгчийн 17 оны Ерөнхийлөгчийн сонгуулийг нийтдээ 45 дипломат төлөөлөгчийн газрыг түшиглэн 45 салбар комисс байгуулан ажилласан. Уг сонгуульд 7211 сонгогч оролцохоо илэрхийлсэн боловч санал хураалтын эхний шатанд 4816 буюу 66.8 хувь нь оролцсон. 2 дахь шатын сонгуульд нь 2799 буюу 37.7 хувь нь оролцсон байдаг. 17 оны сонгуульд нийтдээ 509 сая төгрөг гаруй төгрөг зарцуулсан байсан. 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд мөн нийтдээ 44 дипломат төлөөлөгчийн газрыг түшиглэн 44 салбар комисс байгуулан ажилласан. Энэ сонгуульд 7394 иргэн сонгогч оролцохоо илэрхийлж

бүртгүүлсэн боловч санал хураалтад 5618 буюу 76 хувийн ирцтэй санал өгсөн байдаг. Сонгуульд нийтдээ 385 сая гаруй төгрөг зарцуулсан байдаг. Миний мэдээлэл дууслаа.

Г.Ганболд: Баярлалаа. Гадаад улсад байгаа сонгогчдоос санал авах ажиллагааны талаар СЕХ-ны дарга Дэлгэрнаран мэдээлэл танилцуулна.

П.Дэлгэрнаран: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Ингээд би та бүхэнд бол товчхон тоон мэдээллүүдийг эхлээд өгье гэж бодож байна. Ер нь Сонгуулийн хууль тогтоомж өргөн баригдаж байгаатай холбогдуулаад сүүлийн жилүүд энэний өмнөх ээлжит сонгуулиас хойших хугацаанд СЕХ бол олон улсын болоод дотоодын шилдэг туршилагууд, тэгээд шинэ арга барил юу байна, одоо нэвтрүүлэхэд хууль тогтоомждоо юуг хуульчлуулах вэ, дэвшил яаж гаргах вэ гэдэг талаар судалгаа, сургалт зохион байгуулж, бид нар ингээд хууль хуулийн төслийг боловсруулах энэ ажил процесст бол бид нар идэвхтэй оролцож ирсэн.

Би бол одоо гадаад улсад байгаа сонгогчдоос санал авах ажиллагаа гээд энэ, энэ дээр байгаа 1 товчхон хэдэн тоог та бүхэнд хэлье. Би энэ эхний энэ тоо байна. Энэ тоо бол ер нь манайх энэ олон улсын түвшинд энэ дэлхийн бусад улс орнуудтай харьцуулбал энэ гадаадад байгаа иргэдийнхээ саналыг хэрхэн авч байгаа, аль ангилалд аль тоон дотор бид нар багтаж явж байна вэ гэдгийг та бүхэнд товч танилцуулъя.

Тэгэхээр дэлхийн 200 энэ бол IDEA буюу олон улсын ардчилсан сонгуулийг бол дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн ийм тоо статистик байгаа. Тэгэхээр энэ бол дэлхийн 216 улсаас 150 улс нь бол өнөөдөр гадаадад байгаа иргэдийнхээ саналыг ямар 1 хэлбэрээр авч байгаа. Тэгэхээр эндээс энэ 150 улсаас 125 нь бол хууль тогтоох байгууллагынхаа сонгуульд, Ерөнхийлөгчийнхөө сонгуульд

бол 89 улс, ард нийтийн санал асуулгад бол 75 улс явж байгаа. Тэгэхээр манайх бол энэ 216 улсын энэ гадаадад байгаа иргэдээ аль 1 хэлбэрээр иргэдээсээ саналаа авдаг 150 улс дотор бол багтаж байгаа юм.

Ингээд энэ санал авч байгаа улсуудаас бол саналаа ямар, ямар хэлбэрээр авдаг юм бэ гэж ингээд. Санал авах байраар 109 улс гадаадад байгаа иргэдийнхийгээ авдаг. Шуудангаар бол 53 улс, цахимаар 15 улс, итгэмжлэгдсэн хүнээр бол 19 улс гээд. Ингээд өнөөдөр бол дэлхийн 216 улсын улсаас бол 15 улс бол цахимаар гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авч чадаж байгаа. Манайх бол энэ санал авах байраар авдаг энэ хэлбэрт энэ 109 улсын дунд бол багтаж яваа.

Дараагийнх нь болохоор бид нар энэ тоог та бүхэнд танилцуулъя. Гадаад улсад манай оршин сууж байгаа иргэдийн ерөнхий статистикийг та бүхэнд танилцуулъя. Энэ бол энэ эхний энэ хэсэг дээр бол юу вэ гэхээр энэ хүн ам орон сууцын улсын тооллогын дүнгээр 10 жил тутам 1 явагддаг. Энэ бол 20 оны дүнгээр бид нар авсан байгаа 20 оны дүнгээр бол 122300 хүн гадаадад оршин сууж амьдарч сурч байна. Энэ бол 2010 онтой харьцуулах юм бол 14.2 хувиар гэж байгаа. Мэдээж энэ 20 оноос хойш 30 онд дараагийн тооллого болох байх. Гэхдээ 2023 он энэ 3 онд бол яаж өөрчлөгдөж байгаа гэхээр мэдээж олон болох тал руугаа өөрчлөгдөж байгаа юм шиг байгаа юм.

Энэ нь юу гэж баталж байна вэ гэхээр энэ талын энэ хэсэг дээр бол ГХЯ-ны статистик тоо ингээд байж байгаа юм. Энэ бол өнөөдрийн байдлаар ГХЯ-ны статистик тоогоор сая Золбаяр дарга бид 2-ын статистик зөрж байна. 176000 гэж байна. Одоо миний энэ дээр бол 197280 хүн гэж байгаа. Дэлхийн 90 улсад амьдарч байгаа. Энэнээс бол хамгийн олон амьдран сууж байгаа улсууд гээд манай иргэд амьдарч, ажиллаж байгаа улсууд гэх юм бол Солонгос улс, АНУ, Япон, Чех,

Швед гээд ингээд энэ улсууд ингээд багтаж байгаа юм. Энэ гадаадад оршин сууж байгаа иргэдийн ерөнхий статистикийг танилцуулахад ийм байгаа юм.

Одоо сонгуулиа манайх зохион байгуулж, гадаадад байгаа иргэдээсээ авсан ерөнхий дүн статистикийг та бүхэнд танилцуулъя. Манайх бол 12 оны парламентын сонгууль, 13 оны Ерөнхийлөгчийн сонгууль, 17 оны Ерөнхийлөгчийн сонгууль, тэгээд 21 оны Ерөнхийлөгчийн сонгуулиудаар гадаадад байгаа иргэдээсээ санал авсан. Энэ дээр бол саяын манай гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн статистик тоотой харьцуулаад та бүхэн өөрсдөө дотроо дүгнэлт хийж үзээрэй. Тэгэхээр ингэхээр энд бол энэ өнгөрсөн сонгуулиудад яаж явагдсан гэхээр 2 ажиллагаа явагдсан. Дараалсан 2 ажиллагаа. Эхлээд гадаадад байгаа иргэдээ тухайн ЭСЯ, дипломат төлөөлөгчийн газруудад бүртгэх ажил явагдаад, дараа нь санал хураах ажил ингээд 2 тусдаа явагдсан, 2 дараалж яваг.

Энэ маань бол манай гадаадад байгаа хүмүүсийг саналаа өгөхөд бас нэлээн төвөгтэй 2, 3 удаагийн явалт болж, ийм энэ төвөгтэй болсон нь тоо баримтаас бол шууд харагдаж байгаа. Ингээд бүртгүүлэхдээ болохоор бол арай илүү олон хүн бүртгүүлдэг. Яг саналаа өгөхдөө бол 2000, 1000 гаруй, 3000 шахуу хүмүүсээр зөрүүтэй болдог. Нөгөө хүмүүс маань бол ирж саналаа өгөхдөө өгдөггүй. Хамгийн сүүлийн жишээ гэх юм бол 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар бол 7398 хүн эцсийн дүнгээрээ 94 хүн ингэж бүртгүүлээд санал өгөхдөө 5668 хүн саналаа өгсөн байх жишээтэй. Тэгэхээр энэ бол юу харуулж байна вэ гэхээр гадаадад байгаа иргэдийн саналыг авахдаа бүртгэлийг тусад нь, санал авах ажлыг тусад нь ингээд дараалуулж хийхээр олон удаагийн явдал болоод, нөгөө иргэдэд маань чирэгдэл үүсээд, ингээд ирцэд бол хангалтгүй ийм сөрөг нөлөө

үзүүлж байна гэсэн ийм дүгнэлтэд хүрч болохоор байгаа юм.

Тэгээд бид нар бол гадаадад байгаа иргэдийнхээ саналыг энэ 24 оны ээлжит Улсын Их Хурлын сонгуулиар сонгуулийн хууль тогтоомж маань нөгөө холимог тогтолцоотой байхаар тусгагдаад явж байгаа учраас бид нар бол энэ пропорциональ тогтолцоо дээр пропорциональ намын жагсаалт дээр бол гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авна. Одоо явж байгаа өргөн баригдаад явагдаж байгаа хуулийн төслүүд дээр бол энэ тусгагдаад энэ асуудал тусгагдаад, зохицуулагдаад явж байгаа учраас бол бид нар бас бэлтгэл ажлыг хангах, тодорхой хэмжээний тооцоолол хийж үзэх ийм ажлууд бол хийгдэж байна. Сонгуульд иргэдийнхээ саналыг авах, өөрөөр хэлбэл санал өгөх ажлыг зохион байгуулахаас гадна бид нар бол бас сонгууль юм чинь сонгохоос гадна сонгогдох эрхийг эдлүүлэх энэ эрхийг хангах асуудал маш чухал байгаа. Энэ хоёрын чинь нийлбэрээрээ сонгууль болно. Түүнээс бол дан сонгох эрхийн асуудал бас биш, сонгогдох эрхийн асуудал яригдах учиртай.

Тэгэхээр бид нар бол урд талын сонгуулиуд дээр ямар хугацаанд, ямархуу, ингээд сонгуулийн үргэлжилж байгаа хугацааны аль хэсэг дээр бид нар гадаадад байгаа иргэдийнхээ саналыг авч байсан бэ гэдгийг энэ зураг дээрээс харж болно. 12 оны парламентын сонгууль дээр бол энэ хөхөөр тэмдэглэгдсэн байгаа нь бүртгэлийн ажил. Бүртгэлийн ажил, одоо гадаадад байгаа иргэдийг саналаа өгөхийг бүртгэж байгаа хугацаа энэ 6 сарын 11-нээс эхлээд 6 сарын юу, 5 сарын 11-нээс эхлээд 5 сарын 30 хүртэл явсан байгаа. Дараа нь энэ ногоонуудаар гээд ингээд харагдаж байгаа энэ зурааснууд болохоор сурталчилгааны хугацаа эхэлсэн үеийг харуулж байгаа ийм юм байгаа. Тэгээд яг сурталчилгаа явж байх үеийн яг аль хэсэг дээр тэр улаанаар тэмдэглэсэн гадаадад байгаа иргэдийг саналыг авсан бэ гэдгийг харуулж байгаа. 12 онд бол 6

сарын 10-ны өдөр сурталчилгаа эхлээд 4 хонож байхад бол саналыг авсан байгаа.

Тэгэхээр бол бид нар чинь нэр дэвшиж байгаа хүмүүс, нам бол өөрийнхөө мөрийн хөтөлбөр юмаа бол ард нийт, сонгогчдодоо танилцуулах энэ боломжийг нь бас харж байж энэ саналыг хураах ёстой. Түүнээс бол зүгээр зохион байгуулалтынхаа зөвхөн зохион байгуулалтын талаас нь хараад яагаа ч үгүй эрт авах юм бол бас нөгөө сонгогдох эрхийг хангахад бас сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа учраас одоо 24 оны ээлжит сонгууль дээр бид нар бол аль болохоор нийтээр санал хураах өдөр рүү дөхүүлж авах асуудал байгаа. Тэгээд энэ өргөн баригдсан хуулиудын төслөөр бол 4 хүртэл өдөр гэсэн өдрөөр яаж байгаа. Энэ санал авах өдрүүдийг бол СЕХ тогтоож, санал хураалтыг зохион байгуулахаар ингэж тусгагдаж явж байгаа юм.

Тэгэхээр бид нар бол энэ 24 оны одоо санал хураалтыг явуулахдаа илүү урт хугацаатай байлгая, яагаад гэвэл гадаадад байгаа иргэд маань илүү боломжтой. Ингээд 4 хоногийн бүтэн 4 хоногийн хугацаанд ингээд тавьж үзээд бид нар зохион байгуулалтын ажлаас хойшоо суухгүй, энд бэрхшээхгүйгээр шууд ингээд энэ хугацаанд сайн ажиллах юм бол иргэдийг илүү оролцох бололцоогоор хангана. Тэгээд бүртгэл санал хураалт хоёрыг бол 1 болгоно гэсэн ийм тооцоотойгоор дахин, дахин явалт хийхгүй гэсэн ийм зохицуулалт явагдаад, энэ дээр ийм асуудлууд шийдэгдэж байгаа. Тэгээд санал хураалтыг санал хураах өдөр рүү аль болохоор дөхүүлж өгнө гэсэн ийм тооцоололтой байж байгаа.

Энэ дээр дараагийнх нь бол энэ дипломат төлөөлөгчийн газар гэж ингээд хэлэхээр ЭСЯ, ОУБ-ын дэргэд суугаа байнгын төлөөлөгчийн газар гээд ингээд ингэж явж байгаа. Тэрнээс гадна ГХЯ-тай зөвлөлдөөд хуулийн өргөн баригдсан хуулийн төслүүд дотор явж байгаа 1 ийм

шинэ заалт орж ирж байгаа. Энэ төв комиссын санал болон төв комисс гэдэг нь бол ГХЯ дээр байгуулагддаг. Гадаадад байгаа иргэдийн саналыг авах ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг хэлж байгаа. Энэ санал болон сонгогчдын тоог үндэслэн дипломат төлөөлөгчийн газар байрладаггүй газарт энэ хуульд нийцүүлэн салбар комисс байгуулж болно л гэсэн ийм юу бол явж байгаа юм, болно гэж. Өөрөөр хэлбэл энд бол дипломат төлөөлөгчийн газар байхгүй мөртөөсөө маш их олон хүн ажиллаж амьдардаг тодорхой газрууд байгаа. АНУ гээд л тэгэхэд Кларидо байна, Австралийн Холбооны улс гэхээр Сидней, Мелбурн гээд ингээд, Канад улс гэхэд Калгир, Ванкувер гээд ингээд ийм газруудад бид нар бол хэсгийг санал хураах хэсгийг байгуулаад, ингээд аль болохоор олон хүн хамруулаад авах арга юу байна. Яг дан ингээд дипломат төлөөлөгчийн газрууд руугаа ингээд татна гэхээр зэргэлдээ буюу тэрнээс нэлээн алслагдсан байгаа хотуудад олноороо ажиллаж, амьдарч байгаа улсууд бол саналаа өгөхөд бас хүндрэлтэй байдаг. Тэгэхээр бид нар ийм шинэ 1 дэвшил гарах ийм боломж байна гэж үзэж, энийг ингээд хэлж төсөлд тусгаад явж байгаа. Дараагийнх нь болохоор.../үг тасрав/

Г.Ганболд: Ер нь шийдлээ л голлож, саналуудаа л гол нь явуулбал их сайн байна.

П.Дэлгэрнарэн: Ингээд энэ бид нар бол энэ ГХЯ-ны саналаар зохион байгуулдаг энэ төв комиссыг бол бид нар цөөхөн 5-7 хүнтэй байгуулдаг байсан бол 9-11 хүнтэйгээр байгуулна. Төв комиссоо бол тухайн улсууд руугаа нэлээн тарааж, томилж ажиллуулна. Тэгээд энэний үр дүнд бол гадаадад байгаа иргэдийн зохион байгуулалтын арга хэмжээг бол нэлээн идэвхжүүлснээр гадаадад байгаа иргэдийн санал өгөх ирцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна гэсэн тооцоолж байгаа. Бусад нь бол яах вэ одоо ингээд салбар комисс гээд байвал тухайн ЭСЯ-ан дээр байгуулагддаг бол ингээд 2, 4. Энэ

угаасаа хүний нөөцийн хүрэлцээнээс хамаараад яах вэ энэ чигээрээ байлгая. Төв комиссоо нэлээн идэвхжүүлэе гэсэн ийм тооцооллоор бид нар явж байгаа.

Дараагийнх нь энэ гадаад улсад байгаа иргэдийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг үйлдэхдээ энэ хууль дээр өргөн баригдсан хуулиудын төсөл дотор бол энэ тухайн Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар гээд ингээд энэ 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх мэдээллүүдийг Улсын бүртгэлийн газарт хүргүүлэхдээ Гадаад хэргийн яам гэсэн нэрийг бол нэмэх төсөл явж байгаа. Тэгэхээр энэ Гадаад хэргийн яамны оролцоо бол энэ нэрсийн жагсаалт гаргахад статистик тоо баримт эд нараа бол энэ рүү орж өгөх ёстой гэж ингэж бид нар үзэж байгаа. Зохион байгуулалтын хувьд бол энэ нь илүү оновчтой болно гэж үзэж байгаа юм.

Дараагийнх нь болохоор бид нар энэ гадаад улсад байгаа иргэдийн иргэдийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг үйлдэхдээ санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ гэж ингэж байгаа. Тэгэхээр сонгогчдын нэрсийн жагсаалтыг санал авах өдрөөс 5-аас доошгүй хоногийн өмнө хэсгийн хороонд хүргүүлнэ гэж ингэж байгаа. Тэгэхээр энэнээс өмнө энэ чинь энэ хэсгийн хороо гээд байгаа нь бол манай нутаг дэвсгэрт байгаа улсын нутаг дэвсгэрт байгаа хэсгийн хороодыг хэлж байгаа. Тэгэхээр энэ 5-аас доошгүй хоногоос өмнө гадаадын иргэдийн саналыг бас авч дуусах шаардлагатай болж өгч байгаа. Тэгэхээр яагаад вэ гэхээр энд байгаа нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн, саналаа өгсөн иргэдийн мэдээллийг update хийж, улсын бүртгэлийн газар дахин нөгөө хэсгийн хороонуудад хүргэх ийм ажил хийгдэнэ гэж ингэж зохион байгуулалтын хувьд бол бид нар үзэж байгаа юм.

Дараагийнх нь болохоор бид нар энэ шинэ өргөн баригдсан хуулийн төслөөр бол пропорциональ, мажоритар 2

элемент зэрэгцэж явж байгаа. Тийм учраас бол бид нар та бүхэнд энд гишүүд байж байна. Ер нь ингээд энэ өргөн баригдсан төслүүдээр бид нар ингээд батлагдлаа гэж бодоход ер нь саналын хуудас маань эцсийн дүндээ яг ямархуу юм болох нь вэ гэдгийг бид нар хийж үзсэн. Саналын хуудас маань бол яг ийм юм болж байгаа. Энэ ийм 2 ар, өвөргүй ийм 2 хуудас болж байгаа юм. Одоо манайд ашиглагдаж байгаа энэ төхөөрөмж маань бол хамгийн урт нь 22 инч буюу 56 орчим сантиметрийн ийм саналын хуудсыг бас унших хүчин чадалтай. Тэгэхээр энэ бол хамгийн урт нь. 22 инчийн саналын хуудас.

Тэгээд энэ дээр бол яах вэ гэхээр мажоритар хэсэг дээрээ энэ оройн хэсэг дээр юу гэдэг юм 2 нь 2 мандаттай, 1 нь 1 мандаттай байна гээд, ингээд манайд бүртгэлтэй 37 нам бүтэн нэрээ дэвшүүлээд, бүгдээрээ нэрээ дэвшүүлээд, тэгээд дараа нь нэрсийн жагсаалт буюу нөгөө явж байгаа 38 хүнээ 37 нам маань нэр дэвшүүлээд, ингээд бүтэн нэр гаргаад, ингээд явахад бол саналын хуудас яг ийм болох юм. Эндээс бол юу үүсэх вэ гэхээр энэ бол яах вэ одоо манай техникийн үзүүлэлт бол манай төхөөрөмж бол уншина, ар, өвөргүй уншиж болно. Программчилна энийгээ бол. Тэгэхдээ энийг бол урьд нь бол манайх яг ийм дээд хүчин чадлаар ашиглаж байсан тохиолдол бол байхгүй. Тэгэхээр энийг энэ удаагийн энэ хуулийн төсөл ингээд батлагдаад яваад, тэгээд намууд бол яг бүтэн хэмжээгээр хүмүүсээ нэр дэвшигчдээ дэвшүүлээд ингээд явахад бол саналын хуудас маань 1 иймэрхүү саналын хуудас болж байгаа.

Тэгэхээр энэ бол бид нар техник технологийн хувьд бол маш сайн бэлтгэл хангах зайлшгүй шаардлагатай гэж үзэж байгаа. Ийм юм байгаа юм. Ингээд танилцуулга дууслаа, та бүхэнд баярлалаа.

Г.Ганболд: Баярлалаа. Магнайсүрэн дарга БХБЯ-ны мэдээлэл.

С.Магнайсүрэн:

БХБЯ

Магнайсүрэн. Хаягжуулалтын хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой асуудлыг товч танилцуулъя. Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигт газар зүйн мэдээллийн системд тулгуурласан хаягжилтын нэгдсэн сан бүрдүүлж, иргэд, байгууллагын хэрэглээнд нэвтрүүлнэ гэж ингэж зорилт дэвшүүлсэн. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хаягжилтын нэгдсэн системийг Монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно гэсэн ийм 2 том зорилтыг бол бодлогын баримт бичгүүдэд тусгасан. Энэ хүрээнд БХБЯ 2013-аас 18 оны 5 жилийн хугацаанд улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг бол хийж гүйцэтгээд, тэгээд үүнийгээ үндэслээд Засгийн газраас 2022 онд 180 дугаар тогтоол гаргаад ингээд Монгол Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн системийг бол нэвтрүүлж эхлээд, өнөөдөр энэ системээ бүрэн дүүрэн хэрэглэх энэ асуудал дээр бид нар нэлээн ач холбогдол өгч ажиллаж байгаа.

Энэ ажлын хүрээнд бид нар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, ХЗДХЯ, УБЕГ, тэгээд нийслэл, дүүргүүдтэй бид нар ингэж байнгын хамтын ажиллагаа хийж ингэж ажиллаж байгаа юм. Ингээд энэ ажиллаж байх явцад хэд хэдэн асуудлууд байгаа. Эхлээд бид нар бол ямар ч байсан хууль, эрх зүйн орчноо бол Стандарт, хэмжил зүйн газартай хамтраад энэ стандартуудаа бол бэлэн болгосон. 3 стандарт хаягийн бичвэрт тавигдах шаардлага, хаягийн орон зайн өгөгдлийн үзүүлэлт, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавигдах шаардлага гээд стандартуудаа бол батлуулаад гаргачихсан. Хаягийн хаягжуулах журамдаа эхний ээлжийн бол зохих өөрчлөлтүүдийг хийгээд мөрдөж байгаа.

Хаягийн мэдээллийн сангаа хэрэглээнд нэвтрүүлэх шийдвэрээ бол гаргачихсан.

Одоо хамгийн гол нь бид нар Хаягжуулалтын тухай хуулиа шинэчлэх шаардлагатай байгаа. Яагаад гэвэл энэ хууль маань 13 онд батлагдахдаа ерөөсөө л 1 хуудас хагас ийм 1 бүлэг, 5 зүйлтэй ийм маш товч хууль тухайн үед бол ингээд цаг хугацааны бас ийм шаардлагаар гарчихсан юм байна лээ. Тэгээд өнөөдөр бол бид нар энэ хуулийн төслөө бүрэн дүүрэн шинэчлэх шаардлагатай гэж үзээд бид нар ойрын хугацаанд оруулж ирэхээр ажиллаж байна. Одоо бол бид нар 7 бүлэг, 25 зүйлтэй олон улсын жишигт нийцсэн ийм цогц системийг бий болгох нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг бол хаягжуулалтыг хангах, зарчмаа тодорхойлох, газар зүйн нэрийн бүрдэлт энэ хаягийн мэдээлэл дотор газар зүйн нэрийн бүрдэл, хаягийн стандартын зохицуулалтуудыг хуульчилж өгөх, хаягийг объектод суурилж олгох болон шуудангийн код, бүсчлэлийн код, zip кодтой болгох, гудамжны нэр, барилгын дугаарыг өөрчилснөөс үүсэх хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх ийм асуудлуудыг тусгаад, ингээд энэ хуулийн төслөө оруулж ирэхээр бэлдсэн байгаа.

Удахгүй бид нар энэ үзэл баримтлалыг нь батлаад, Засгийн газрын хуралдаанд бид нар 5, 6 сарын хугацаанд оруулаад Засаг руу Их хурал руу оруулж ирэх байх. Засгийн газрын хаврын энэ хаврын хэлэлцэх асуудлын 2 дугаар улирлын төлөвлөгөөнд бол орчихсон ингээд явж байгаа.

Системд нэвтрүүлэх, систем бий болгохтой холбоотой хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулах ажлын хүрээнд бид нар 1-ийг харьцах нь 100000-ны масштабтай газар усны нэрийн тоон зургийн 258650 газар усны нэр, 223608 нь замын өгөгдлийг үүсгэж, гудамжийг замтай холбон эхлэл төгсгөл, нэгж талбар, барилгын орц гарцыг тэмдэглэж, стандартад нийцүүлэн бүрдүүлсэн

өгөгдлүүдийг тооцоолж, нэгж талбар барилгын хаягийг автоматаар олгох ийм нөхцөлийг бол бүрдүүлсэн байж байгаа өнөөдөр бол. Ингээд энийгээ бол Egazer.gov.mn, Egazar mobile application-аар бол мэдээллийн санд суурилсан зам заагч функцийг ашиглаж, ашиглах боломжтой. Тэгээд ХУР болон ДАН системээр энийг ашиглах ийм нөхцөлүүдийг бол үйлчилгээнд гаргах нөхцөлийг бол бид нар бол бүрэн бүрдүүлсэн.

18 оноос хойш энэ нөхцөлөө бүрдүүлсний дараа 21 аймгийн хэмжээнд нэвтрүүлж явж байна. Өнөөдрийн байдлаар 21 аймгаас 241 суманд бол тус системээс хаяг олгож, холбогдох журам стандартын дагуу тэмдэгжүүлэх ажил явж байна. Ингээд энэ нь бол улсын хэмжээнд 66.6 хувьтай байна гэсэн ийм тоон дүн гарч байгаа.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас хаягийн мэдээллийн санд өнөөдөр бид нар 1181155 нэгж талбар бүртгэсэн байгаа. Үүнээс 564.9 мянга нь эзэмшил, 7000 нь бол ашиглалт, 609000 нь өмчлөл байгаа. Эдгээр нэгж талбар дээр 741.8 мянган барилга байгууламж бүртгэлтэй байгаа. Ингээд энэ тоон бүх энэ тоонууд дурдаад байгаагийн учир нь болохоор зэрэг улсын бүртгэл болоод манай энэ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, тэгээд манай орон нутгийн энэ албад дээр байгаа энэ бүртгэлүүдийн хоорондын зөрүүний асуудал бол багагүй хэмжээнд байгаа нь бидний энэ хаягийн мэдээллийн системийг шууд хэрэглээнд нэвтрүүлэхэд бол том саад болж байна.

Тэгээд одоо би яг ямар асуудлууд байна вэ гэхээр зэрэг тухайлбал Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй газар өмчлөлийн Г дугаартай 516204 хаягийн мэдээллийг манай агентлагийн хаягийн системд бүртгэлтэй өмчлөлийн 609191 хаягийн мэдээлэлтэй тулгаж үзэхэд нэгж талбарын дугаараараа 338.1 мянга буюу 65.5 хувь нь л таарч байгаа.

Бусад нь бол ингээд ямар нэгэн байдлаар зөрүүтэй ийм байдал бол гарч ирсэн.

Хоёрдугаарт нь манай агентлагийн хот байгуулалтын системд бүртгэлтэй 741.8 мянган барилгын мэдээллийг УБЕГ-ын бүртгэлтэй 267.8 мянган барилгатай тулгахад 152000 нь л таарч байгаа юм. Энэ улсын бүртгэл манай хоёрын тоо зөрдөг нь бол улсын бүртгэл дээр ингээд хаалга болгоноороо байдаг нөгөө үл хөдлөх хөрөнгө гэдгээрээ. Манайх бол барилга гэдгээрээ байдаг учраас ийм тоо зөрүүтэй байгаа. Гэхдээ таарах ёстой мэдээллүүд нь таарахгүй, ийм хол зөрүүтэй байгаа бас юм бий.

Хаягийн мэдээллийн системд бүртгэгдсэн нийслэлийн хэмжээний мэдээлэлд шалгалт хийж үзэхэд 18 оноос хойш шинээр олгогдсон 434000 нэгж талбарт 24.2 мянган зам гудамжийг зураглаж, орц гарц зураглах шаардлагатай байгаа нь тогтоогдсон. Ингээд бид нар цаашид ямар асуудлыг төлөвлөж байна гэхээр зэрэг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай бид хамтарсан ажлын хэсэг байгуулаад ингээд ажиллаж байгаа юм. Энэ хүрээнд бид нар 22 оныхоо ажлыг бол бүрэн хийж хэрэгжүүлсэн гэж, саяын шалгалтуудыг маш их цаг хугацаа зарж, хүн хүч ажиллаж байж гаргаж ирсэн. Одоо бид нар 23 онд 18 ажил ингээд төлөвлөсөн байгаа.

Энэ дотор хамгийн эхлээд ярихад нэгдүгээрт бол энэ зөрүүтэй мэдээллүүдээ арилгах, нэгдсэн мэдээлэлтэй болгох ажлыг манай агентлаг УБЕГ-тай хамтарч ажиллаж хийнэ гэж ингэж төлөвлөгөөндөө нэгдүгээрт оруулж байгаа. Тэгээд энэ бол хамгийн чухал ажил. Энийг бол бид нар бүх боломжоороо дайчлаад ажиллахад 5 сард багтаагаад дуусгачих болов уу гэсэн ийм байдлаар хугацаагаа шахсан байгаа.

Хоёрдугаарт нийслэлийн хэмжээний тэр 18 оноос хойш шинээр олгогдсон гудамж, орц, гарцуудыг зураглах ажлыг бид нар 5 сард багтааж хийж гүйцэтгээ гээд Нийслэлийн Засаг даргын зөвлөлөөс 172 сая төгрөг шийдсэн байж байгаа. Энийг бол ингээд оруулж байгаа. Энэ дээр бол бид нар хөрөнгө мөнгө хэмнээд 20 хүн 20-30 хүн тогтвортой сууж ажиллуулахаар ингээд ажил нь эхэлчихсэн. Маргааш бас бид нар газар дээр нь шалгах гэж байгаа.

Хоёрдугаарт нь энэ 2 ажил хийсний дараа нөгөө хаягийн мэдээлэл дээр шинэ хаягийн дугаарлалт олгох ажлыг зохион байгуулах буюу программ хангамжаа цэгцлэх ажил. Энийг бол энэ 2 ажил хийгдчихвэл 14 хоногийн дотор хийнэ гэж тооцож байгаа.

Дараа нь бид нар энэ дундын мэдээллийн санг Цахим хөгжил, харилцаа холбооны яаман дээр буюу тэр улсын дата төв дээр ч юм уу ингээд бий болгох ёстой. Энийг бол 6 сард хийнэ гэж ингэж тооцож байгаа. Ингээд нэгдсэн системээ нэвтрүүлэх ажлаа бол бид нар Засгийн газрын хуралдаанд оруулаад, дараа нь Хаягжуулалтынхаа хуулийг ингээд оруулж ирнэ гээд ингээд 9 сард үндсэндээ бид нар энэ бүх юм цэгцэрнэ гэж тооцож байгаа.

Энэтэй холбоотой 1 том асуудал бол хуулиараа орон нутаг нөгөө энэ хаягийг ингээд нөгөө орон нутаг дээрээ яг олгож ингэж нөгөө хаягжуулж пайз юу хаягууд хадах ёстой ийм ажил нь үлдэж байгаа. Энэ дээр бол зөвхөн нийслэл дээр гэхэд 19.1 тэрбум төгрөгийн тооцоо урьдчилсан байдлаар гаргаад ингээд ажлын хэсэгт ирүүлсэн байна лээ. Бүх хаягийг шинэчилж ингээд цэгцлэхэд гэсэн ийм тооцоо гаргасан байна лээ. Ингээд бид нар бол энэ саяын дурдсан хугацаанд бол асуудлаа шийдчих бол бололцоотой гэсэн ийм байдлаар төлөвлөлт гаргасан байгаа юм. Баярлалаа.

Г.Ганболд: Мэдээлэл өгсөн дарга нарт баярлалаа. Тэгээд өнөөдрийн манай хурлын хамгийн гол зорилго бол удахгүй болох Улсын Их Хурлын сонгуулийн өмнө Улсын Их Хурлын шинэ хууль Сонгуулийн хууль орж ирж байгаатай холбогдуулаад өмнө нь гарч байсан тийм хүндрэл бэрхшээл шийдэж чадахгүй байсан зүйлүүдийг ер нь хуультайгаа цуг явуулъя гэсэн ийм зорилго байгаа юм.

Энэний 1 нь бол мэдээж гадаадад байгаа иргэдийн хувьд тэр хүмүүсийг яг санал хураалтад оруулах уу, оруулах юм бол яг мажоритар дээр нь яаж оруулах юм, пропорциональ дээр нь яаж оруулах юм. Тэр битгий хэл бүр сая Магнайсүрэн даргын мэдээлэл дээр бол хэний Дэлгэрнарэн даргын мэдээлэл дээр бол 197280 иргэн гадаадад байна гэж байна шүү дээ. Тэгээд бүр бие даасан гадаадад байгаа иргэдийг төлөөлсөн 1 бүр тойрог Их Хурлын 1 тойрог байх уу, үгүй юу гэдгийг хүртэл бид нар ярих ёстой байхгүй юу ер нь. Гадаадад байгаа иргэдийг л төлөөлсөн бүр тойрог байхыг бид нар үгүйсгэхгүй. Тэгээд энэ болгоныг бид нар 1 ярих ёстой.

Тэгээд ер нь бол цаашидаа энэ хаягжилтын асуудал байнга 1 маргаантай байгаа энэ хаягжилтын асуудал энэ улсын бүртгэлийн асуудлуудаа 1 цэгцэлчихье, шийдчихье. Энэ хүрээнд бид нар бол өнөөдөр нөгөө дэд хороо хуралдаж байгаа нь Сонгуулийн хуультай дагуулаад бас маргаантай байгаа асуудлаа шийдчих ийм юмыг дагуулж оруулъя гэдэг ийм зорилгоор л өнөөдрийн хурал зохион байгуулж байгаа шүү дээ. Тэгээд мэдээлэл өгсөн дарга нарт баярлалаа. Мэдээж бид нар бол проблемыг бол бүгдээрээ мэдэж байгаа. Сая 4 даргын мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Туваан гишүүнээр тасалъя. Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Энэ сонгогчийн нэрсийн жагсаалттай холбоотой мэдээллүүд орж ирж байна л даа. Энэтэй

холбоотой ер нь нийгэмд байдаг хардлага сэрдлэгээс эхэлье. Сонгууль будилаантай болдог гээд л нэг хэсэг ер нь нийгэмд маш их том хэмжээний хардлага сэрдлэг явдаг. Энэ нь ажиглаад байхад 2 зүйл дээр илүү төвлөрөөд байх шиг байгаа юм. Хар машин худлаа үнэн тоолдог хар машинтай холбоотой 1 гомдол. Нөгөөдөх нь тэр software талдаа буюу улсын бүртгэл нэрсийн жагсаалт гэдэг зүйлтэй холбоотой 2 ийм багц асуудал руу нэлээн тийм төвлөрч, иргэдийн энэ сошиал дээр янз бүрийн л зүйлүүд их гардаг.

Тэгэхээр энийг ер нь 1 тийшээгээ болгож, нэлээн тийм ил тод нээлттэй энэ дээр явахгүй л бол цааш цаашидаа энэ чинь 1 зөвхөн иргэдийн сонгох сонгогдох эрхээсээ гадна энэ төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдал, албан ёсны байдал гээд энэ нь цаана нь их олон том зүйл энэний цаана бас яригдаад байна л даа. Тэгэхээр нэрсийн жагсаалттай холбоотой зүйл дээр түрүүн бас 1 аль даргынх нь байна вэ мэдээлэл дотор зарим системүүд offline горимоор ажилладаг. Offline гэдэг чинь яг нэгдсэн сүлжээнийх бас биш юм шиг байгаа юм. Тэгэхдээ тэр мэдээж цаашаа холбогддог л гэж хэлэх л байх л даа.

Тэгэхээр энэ дээр сонгогчийн нэрсийн жагсаалтын нэгдсэн бүртгэл гэдэг зүйл яг яаж баталгааждаг вэ? Иргэн 1 газар өгөөд, 5 газар, 10 газар дахин давтан өгөөд байна гэж яриад байгаа тэр зүйлийн эсрэг яг ямар баримт нотолгоо, яг үнэхээр тийм итгэл үнэмшилтэй нотолгоог бид нар хэлж чадах юм. Одоо нэг тийм зүйл яригдаад байна шүү дээ. Гэтэл яг энэ хуульд сонгогчийн нэрсийн жагсаалтын тийм нэгдсэн бүртгэл гэдэг үг, өгүүлбэр байхгүй байгаа юм. Тэгэхээр энэний цаана энэ дээр 1 ийм тайлбарууд өгөөч.

Эндээс бас 1 асуух асуулт бүр заавал тодорхой зүйл нь сонгогчийн жагсаалтыг зөвхөн өөрийнхийгөө харахаас гадна нөгөө талдаа нөгөө өөрийн гэр бүлийг харахаас гадна хүний тодорхой хэмжээний хувийн

нууцлалуудыг нь хойш нь тавиад бусад улс даяар бүх иргэдийн нэрсийн жагсаалт нээлттэй байж болох уу? Тэрийг бусдаар бүгдээрээ хардаг байж болох уу гэх мэтийн 1 ийм зүйлүүд бас байгаад байна.

Хоёрдугаарт нь тэр хар машинтай холбоотой. Хар машины баталгаажилт яг яаж хийгддэг юм бэ? Аудит, сонгуулийн санал хураахын урд яг олон улсын ямар байгууллагаар яаж сертификат авч яаж баталгааждаг юм бэ? Энэ дээр 1 тайлбарууд өгөөч. Би тэгээд дараа нь тодруулаад асууя.

Г.Ганболд: Дэлгэрсайхан хариулах уу? 2 номерын, 2 номерын микрофоныг өгье.

Д.Дэлгэрсайхан: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үндсэндээ улсын иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд үндэслэж гаргадаг. Яаж баталгаажуулдаг вэ гэхээрээ яг өнгөрсөн сонгуулиар бол бид нар 4 сарын 25-наас 5 сарын 08-ныг хүртэлх өдөр хүртэлх хугацаанд Тагнуулын ерөнхий газар, Сонгуулийн ерөнхий газар, Харилцаа холбоо, мэдээлэл технологийн газрын мэргэжилтнүүдээр бүр гэрчилгээ авч гэрчилгээжүүлдэг юм байгаа юм.

Өөрөөр хэлбэл таны асуусан тэр offline сангууд дээр байгаа давхардал байна уу гэдгийг тусдаа алгоритм гүйлгээж, өөрөөр хэлбэл Дэлгэрсайханы энэ алгоритмаар бусад Дэлгэрсайханы регистрийн дугаараар бусад хэсгүүд дээр давхардсан байна уу гэдгийг нэгдүгээрт ийм шалгаж бүр гэрчилгээ авдаг юм байгаа юм. Ингэж авснаараа бид нар авах процессоо бас ТББ болоод бусад байгууллага энэ дээр бас хяналтыг оруулж ирж явдаг ийм зохицуулалттай болсон.

Нэгдсэн ийм бүртгэл байна уу гэхээр яах аргагүй бид нарын хувьд бол сонгуулийн насны иргэдээ иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас ялгаж л

ингэж явах л хамгийн зөв зохицуулалт. Мэдээж сонгуулийн насны иргэнийг тусад нь бүртгэнэ гэдэг юм уу, энэний тусдаа мэдээллийн сан үүснэ гэдэг бол энэ өөрөө бас боломжгүй зүйл л дээ. Тэгэхээр бид нар бол иргэний улсын бүртгэлийн сангаас тастаж аваад, яг сонгуулийн насны хүмүүс, сонгуулийн хүмүүс энэ байна гээд тусдаа сонгогчдын нэрийн жагсаалт бүхий сан үүсгэдэг л ийм л зохицуулалт байгаа.

Г.Ганболд: Цогтгэрэл гишүүн нэлээн олон юм асуусан л даа. Хар машины нөгөө баталгаажуулалтыг яаж явж байгаа юм. Энийг ер нь бол бас 1 тийм СЕХ Дэлгэрнаран дарга хариулчихъя. Тийшээ 3 номер, 3 номер дээр оччихъё. Тэгээд тэр талаар бас 1 жоохон, одоо ер нь хар машины маань ашиглаж байгаа газрууд нь хэр байгаа юм, энэний баталгаажилт нь яг ямар байгаа юм, аудитын дүгнэлт юу байна вэ? Тэгээд энэний итгэх итгэл талаас нь та нэг тайлбар өгөөч? Сая Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. 3.

П.Дэлгэрнаран: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ хар машин буюу яг албан ёсны хэллэг нь бол санал тоолох төхөөрөмж. Энэ санал тоолох төхөөрөмжийн баталгаажилт нөгөө тухайн сонгуульд хэрэглэх энэ баталгаажилтыг яаж хийгддэг юм бэ гэж асууж байх шиг байна. Тэгэхээр энэ ээлжит сонгуулийн өмнө энэ тухайн төхөөрөмжтэй үзлэг хийгээд, ингээд ТЕГ-ын хяналт доор манайхаас мэргэжлийн хүмүүсийн ТЕГ-ыг оролцуулаад ингээд комисс гарч энэ төхөөрөмжийн үзлэг оношилгоог хийж, баталгаажилт өгч, нэг бүрчлэн гэрчилгээжүүлж байж ингэж байж сонгуульд ашигладаг.

Ер нь бол яг хамгийн гол эрх зүйн акт нь гэвэл тухайн сонгуулийг зарлаад, сонгуулийн ажил эхлээд, тэгээд тэр сонгуульд хэрэглэгдэх энэ төхөөрөмжийг хэрэглэ гэдэг зөвшөөрлийг бол Улсын Их Хурал тогтоол гаргаж зөвшөөрдөг ийм

учиртай. Тэгээд яах вэ ер нь бол гишүүн бол юу яаж байх шиг байна. Энэ төхөөрөмжүүд энэ чинь ер нь одоо ер нь ямархуу байдалд байгаад байна вэ, энэ чинь шаардлага хангаж байгаа юм уу, ямархуу байна вэ гэж ингээд. Яах вэ төхөөрөмж бол ер нь бол хөдөлмөр маш сайн хөнгөвчилдөг ийм төхөөрөмж. Тэгээд энэ манай энэ төхөөрөмж бол их олон улс олон улсад хэрэглэгддэг, АНУ-д ихэвчлэн хэрэглэгдэнэ. АНУ-ын нийт сонгуулийн 40 хувь дээр нь хэрэглэгдэж байгаа ийм төхөөрөмж байгаа. Азийн орнуудаас гэвэл Филиппин, Киргиз гээд ингээд энэ улсуудад хэрэглэгддэг.

Манайх бол энэ төхөөрөмжийг авч хэрэглэснээс хойш бол энэ төхөөрөмжийг бол яах вэ олон нийтийн дунд бол янз янзын яриа гарч, шүүмжлэл дагуулж, тэгээд энийг дагуулаад хууль хяналтын байгууллагуудаар маш олон удаа шалгагдсан ийм юмнууд байгаа. Тэгэхдээ энэ дээр бол яг ийм алдаа гаргасан ийм хууль бус үйлдлүүд хийсэн гэсэн тийм баталгаа нотолгоо бол одоогоор бол байхгүй. Ийм л зүйл яваад байгаа юм. Тэгээд энэ төхөөрөмж маань бол 12 онд анх удаа манайд нийлүүлсэн. АСР1 гэдэг ийм төхөөрөмж байгаа. АНУ-д бол энэ АСР2 нь гарсан. Өнгөрсөн оны 11 дүгээр сард зохион байгуулагдсан завсрын сонгууль буюу парламентын сонгууль дээр энэ АСР2 төхөөрөмж хэрэглэгдэж байгаа.

Тэгээд манай энэ авсан зүгээр нөгөө эд хөрөнгийн бүртгэл бүртгэлд бүртгээд, тэгээд нийт ашиглалтын хугацааг нь бол анх эхлээд 6 жилээр тогтоосон юм байна лээ. Тэгээд энэ бол 18 онд бол ашиглалтын хугацаа дуусна гэж. Тэгэхдээ ингээж ярьсан. Тэгээд 16 онд бол СЕХ-ны даргын захирамжаар ажлын хэсэг томилогдоод, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Тагнуулын ерөнхий газар гээд ингээд энэ газруудаас оролцоотойгоор үзлэг оношилгоо хийгээд, тэгээд ашиглалтын хугацааг нь бол дахиад 6 жил буюу 24 он хүртэл, хүртэл гэдэг үг байгаа. Энэ хүртэл гэдэг ийм үгтэйгээр бол

ашиглалтын хугацааг 24 он хүртэл ингээж сунгасан байгаа.

Энэ онд бол бид нар өнгөрсөн онд 22 онд бид нар нэг бүрчлэн яг үйлдвэрлэгчийн паспортын дагуу тест хийж үзлэг хийсэн. Энүүгээр бол бид нар 200 гаруй төхөөрөмж бол ер нь бол цаашид ашиглах боломжгүй гэдэг эхний дүгнэлт гараад Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт акталъя, данснаас хасъя гэдэг ийм санал хүргүүлээд байгаа. Одоогоор бол яг бид нарын дунд бол бид нарт бол ер нь ашиглагдаж болохоор 2493 төхөөрөмж бэлэн байна. Тэгээд энэ бол одоо.../минут дуусав/

Г.Ганболд: Дэлгэрнаран дарга 2024 он хүртэл гэдэг үгээс чинь бодох юм бол 23 оны 12 сарын 31-нд хугацаа дуусна гэж ойлгож болох уу? 3 номерын микрофон өгье.

П.Дэлгэрнаран: Энэ бол тийм. Таны санал ойлгож байгаа бол зөв. Би ч гэсэн яг хуулийн ойлголт нь бол хүртэл гэдэг бол 24 оны 1 сарын 1 л гэсэн үг. Тэгэхээр энэ бол ашиглалтын хугацаа бол ийм байгаад байгаа. Тэгэхээр бид нар 22 оны улсын төсөвт 22 онд яагаад бид нар 23 онд бол их тайван амгалан сайн бэлдээд, 24 онд бол бэлэн байна гээд бид нар 22 оны улсын төсөвт энэ УБЕГ, манай 2 хамтарсан энэ нөгөө хуруу унидаг төхөөрөмжтэйгөө энэ чинь иж бүрэн. Ер нь 1 зоосны 2 тал л гэсэн үг. 1 нь бол санал тоолох төхөөрөмж, нөгөөх нь хурууны хээ таних буюу улсын бүртгэлийн төхөөрөмж. Энэ 2 чинь нийлж байж энэ сонгуулийн бүртгэлийн төхөөрөмжүүд болж, энэ цахим систем болж байгаа юм.

Тэгээд энэ бид нар бол төсөвт хийгээд оруулсан, хасагдсан. 22 оны төсөвт бол хасагдсан. Тэгээд бид нар бол одоо дахиад энийг бол 24 оны төсөвт суулгана гээд ингээд л явах ёстой. Тэгээд бид нар энэ бас цаг хугацааны хувьд бол бас нэлээн давчуу болж байгаа. Гэхдээ бид нар бол наана нь бас хамгаалалтын ажлууд хийгдэж байгаа. Яагаад гэвэл

одоо байгаа энэ өнгөрсөн онд 22 онд бид нар ашиглаж байгаа АСПИ төхөөрөмжүүдээ нэг бүрчлэн үйлдвэрлэгчийн паспортын дагуу ингэж техникийн үзлэг хийж тестэлсэн маань бол юмыг яаж мэдэх вэ асуудал үүсвэл улсын төсөвт хүндрэл үүснэ гэдэг юм уу, худалдан авах нийлүүлэлттэй холбоотой хүндрэл үүсвэл бид нар энийг хугацааг нь дахин сунгаж болох уу, хугацааг нь дахин сунгаж болох уу.

Тэгээд ер нь бол төхөөрөмжийн маань ажиллагаа ямар байна, техникийн бэлэн байдал ямар байна гэдэг дээр бид нар бол дүгнэлт хийгээд, ингээд бол одоо бид нар бол 2493 төхөөрөмжийнхөө ашиглалтын хугацааг сунгая гээд бас давхар Төрийн өмчийн бодлого, зохицуулалт газар руу бас хандчихаад ингээд байж байгаа. Аль, аль нь энэ зэрэг явуулж байгаа. Ер нь бол энийг далимдуулаад хэлэхэд бол энэ улсын бүртгэлийн газрын төхөөрөмж ч адилхан, манайх ч адилхан ер нь хоёуланг нь бол бүгдээрээ 12 онд нийлүүлэгдсэн төхөөрөмжүүд учраас ер нь бол солих шаардлагатай гэж үзэж байгаа.

Г.Ганболд: Баярлалаа. Өнөөдрийн хурлын зорилго нь энэ л дээ ер нь бол. Ийм болохгүй зүйлүүдээ шийдэх нь зүйтэй гэж бодож байна. Пүрэвдорж гишүүн асууя. Цогтгэрэл гишүүн тодруулъя, Цогтгэрэл гишүүний микрофоныг өгье.

О.Цогтгэрэл: Тэр төхөөрөмжийн баталгаажилт, ашиглалтын хугацаанаасаа гадна тэр software гээд программ хангамж, тэрний цаана байгаа тэр ал алгоритм нь яг яаж баталгааждаг гэдгийг, тэр чинь магадгүй нэг жин хэмжүүр байсан ч баталгаажуулдаг, сертификат өгдөг нэг байгууллага байдаг шүү дээ хөндлөнгийн байгууллага. Олон улсын магадгүй аудитын байгууллага. Лиценз өгдөг байгууллага. Тэр байгууллагуудын хяналт шалгалт яг энэ хар машинд яаж ордог юм бэ? Яг энэ алгоритм нь яг үнэхээр санал зөв тоолохоор байна. Тэрнээс биш бид нар

өөрсдөө үзээд, тагнуулын байгууллага үзээд баталгаажуулчихсан гэдэг бол маш ийм өрөөсгөл, дахиад л нөгөө хардлага сэрдлэгийн чинь үндэс болж байгаа бол тайлбар энэний цаана явж байгаа шүү дээ.

Тэр Улсын бүртгэлийн даргаас тэр нээлттэй жагсаалтыг олон нийтэд тавих боломж байгаа юу? Сонгогчийг бүгдийг нь зөвхөн өөрийгөө хардаг гэр бүлийн гишүүдээ хардаг гэж байна шүү дээ. Тэгэхээр чинь явж байгаа хардлага чинь олон санал авах байрууд дээр зэрэг санал өгөх боломж, энэ нь тус тусдаа нэгдсэн бүртгэлтэй биш учраас магадгүй 2005.../минут дуусав/

Г.Ганболд: 2 номерын микрофоныг өгье. 2.

Д.Дэлгэрсайхан: Дэлгэрсайхан асуултад хариулъя. Мэдээж итгэл үнэмшилтэй байх үүднээсээ нээлттэйгийн асуудал яригдаж байна. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд ер нь мэдээлэл дээр энэ хувь хүний мэдээллийг хамгаалах гээд 1 асуудал байгаад байдаг. Сонгогчдын нэрийн жагсаалт дээр өөрийн нэр, эцэг эхийн нэр, нас, хүйс, гэрийн хаяг гээд энэ хязгаартай мэдээлэл энэ сонгогчдын нэрийн жагсаалт дээр байдаг юм. Үндсэндээ улсын бүртгэл дээр бол хаалттай, хязгаартай, нээлттэй гэж 3 ангилж байгаа. Нээлттэй мэдээллийг opendata.burtgel.gov.mn дээр тавьчихсан байгаа. Хаалттай мэдээлэлд хурууны хээ ордог. Энийг бол хэзээ ч хаашаа гадагшаа гаргадаггүй. Таны хэлсэн яг энэ сонгогчдын нэрийн жагсаалт дээр байж байгаа мэдээлэл бол хязгаартай мэдээлэлд ордог учраас энийг яг 2.2 сая иргэнийхээ мэдээллийг бас нээлттэй тавьчих боломж бас байдаггүй юм.

Дэд сангуудын хувьд бол үндсэндээ энэ маань 1 сан юм байгаа юм. 1 санг бид нар яг тодорхой хугацаанд offline байдлаар.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номерын микрофоныг өгье.

П.Дэлгэрнарэн: Гишүүний бас асуусан тэр нөгөө программ хангамжтай холбоотой, энэ лицензтэй холбоотой гэж ярьж байгаа. Энэ бас нөгөө урд талын сонгуулиуд дээр ч бас яригдаад байсан. Нөгөө СЕХ-ны төхөөрөмжийн лиценз нь дуусчихсан. Энэ бол асуудалтай шүү гээд бас маргаан гаргаж байсан. Тэгээд энэтэй холбогдуулаад бид нар бол энэ төхөөрөмжийг болон программ хангамжийг худалдаж авсан, ашиглалттай холбоотой бүх гэрээ хэлэлцээрүүдийг 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд бол хууль юу үед бол бид нар нийтэд нээлттэй болгосон, иргэдийн хяналт, улс төрийн намуудын хяналтуудыг бол бүгдийг нь оруулж танилцуулсан.

Тэгээд саяын программ хангамжтай холбоотой асуудлуудаар юунуудыг бүх гэрээ хэлэлцээртэй холбоотой, ашиглалттай холбоотой, тэрний үнэн зөв байдалтай холбоотой асуудлуудыг бол нийтэд танилцуулж ингэж явж байгаа. Тэгэхдээ энэ программ хангамжийн лиценз бол Dominion voting компани дээр өөр дээр нь байгаа. Тэгэхээр бид нар бол лицензийнхээ мөнгийг төлөөд.../минут дуусав/

Г.Ганболд: Пүрэвдорж гишүүн асуулт асууя. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

Б.Пүрэвдорж: Би бол хар машинд бол итгэдэг. Ялагдахдаа ч итгэж байсан, 2 удаа ялахдаа ч итгэж байсан угаасаа 1 тийм асуудал байхгүй л гэж үздэг. Тэгэхдээ бол хүмүүсийн хардлагыг давах, дарах ёстой юм байгаа юм. Энийг дарах 1 ажлыг ерөөсөө өнгөрсөн Төсвийн хуулиар МАН санаатайгаар хийгээгүй. Энэ бол 20 хэдэн тэрбум төгрөг байх даа хар машины программ хангамжийн мөнгийг тавиагүй байхгүй юу даа. Энэ бол дахиад нөгөө нэг янз янзын луйвраа хийнэ л гэсэн ийм л бодол байх ишг байгаа юм. Тийм

учраас энэ программ хангамжийг нь авах энэ ажлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргах юм уу яадаг юм ийм ажлууд ямар боломж байдаг юм. Тэрэн дээр бас манай ажлын хэсгийн дарга бас 1 асууж үзээрэй гэж хэлмээр байна.

Хоёрдугаарт нь гол асуудал бол бүртгэл дээр л байгаа гэж үзэж байгаа. Бүртгэл дээр. Би дөнгөж сая тоо бичээд сууж байлаа. Учралын сонгууль. Телевиз дээр 59 хэсгийн хорооноос 5 нь гарч ирсэн. СХД-т 81923 сонгогч санал өгсөн байгаа юм. Тэр тойрог дээр. Тэгээд тэрнийг 59-д хуваахаар 1388 санал 1 тойрог дээр, 1 хэсгийн хороон дээр өгсөн байгаа байхгүй юу 1388. Гэтэл Учрал эхний 5 хэсгийн хороон дээр 13000 санал аль хэдийн авчихсан. Тэгээд энийг хуваагаад үзэхээр нөгөө 1 хэсгийн хорооны дунджаас 1300-гаар илүү гарчхаж байгаа байхгүй юу. Энэ бол ерөөсөө бүртгэлийн луйвар ёстой хаана сайгүй явсан. Энийг бол санаатай зохион байгуулсан гэж би үздэг.

Тийм учраас энэ бүртгэлийг тодорхой болгох, одоо ингээд сая хар л даа. Учрал хүртэл өөрөө манай дээр 8 хүүхэд болчихлоо энэ тэр гэгчихсэн зогсож байсан шүү дээ. Ямар замбараагүй байна. Ийм л байгаад байна. Тийм учраас энэ бүртгэлийн асуудлыг маш нарийн зохион байгуулалттай, ялангуяа энэ бүртгэлийн сонгуулийн бүртгэлийн тэр яг тэрийг дэд хэсэг дээр сөрөг хүчнээсээ хүмүүс оруулах, тэрнийг тэрэн дээрээ бас мэдээж намаас болон тодорхой мэдлэгтэй хүмүүсийг оруулж, тэнд яг ямар луйвар байдгийг мэддэг тэр хүмүүсийг авч, энэ бүртгэлийн асуудлыг цэгцлэхгүй бол болохгүй гэж бодож байна.

3 дахь асуудал бэхэн тэмдэглэгээ заавал хийх ёстой. Бэхэн тэмдэглэгээний мөнгийг хүртэл тавихгүй байна шүү дээ. Тэгээд энэ бүх зүйл дээр мэдээж өнөөдөр бол яах вэ ерөнхий мэдээлэл сонсож байгаа. Тэгээд ингээд яг байгууллага байгууллагууд одоо жишээ нь Улсын бүртгэл, СЕХ, тэгээд бусад байгууллага

байгууллагаараа бүгд дээр нь дэд хэсгүүд гараад, тэрэн дээр яг нарийвчилсан, нарийвчилсан асуултуудыг бид нар хийгээд явна. Бид нарт бас мэдээллүүд байгаа. Энэ хүмүүс чинь ерөөсөө Монголд нууц гэж юм байдаггүй. Та нарын доор ажилласан хүмүүс ийм, ийм юм болсон юм шүү дээ гээд бид нарт мэдээллээ барьж ирдэг байхгүй юу.

Дараагийн Засгийн газарт ажиллахын тулд, өндөр албан тушаалд ажиллахын тулд. Тийм учраас энэ эрх баригчдын өгсөн даалгаврын дагуу янз янзын энэ иргэдийн саналыг луйвраар булааж авч ингээж сонгуулийг будилаантуулдаг ийм зүйл дахин гаргахгүйн төлөө бид нар явах ёстой. Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэвэл та нарыг гэмт хэргээс хамгаалах тухай л асуудал байхгүй юу даа. Тийм учраас ядаж л хамтарсан засаг дараачийн удаа гарна.

Г.Ганболд: Пүрэвдорж гишүүний асуултад хариулна. Тэгээд ер нь яг хэлж байгаа нь зөв л дөө. Ер нь бол бид нар чинь нөгөө сонгууль болсны дараа байнга ингээд нэг баахан олон хүмүүс янз бүрийн ялагдсан хүн болгон гомдол ирдэг. Тэрийг нь араас нь ингээж шалгаад, нийгэмд нөгөө оновчтой мэдээлэл өгөөгүйгээс болоод л ингээд л байнгын л нэг тийм хардалт сэрдэлт, ялагдсан хүн болгон гомдолтой явсаар байгаад ийм болж байгаа юм л даа. Тэгээд саяын тэр Учрал гишүүнтэй холбоотой асуудлыг ингээд тухайн үед нь судлаад ийм байсан юм байна гэхихсэн бол өнөөдөр юм ярихгүй л дээ. Ингээд Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя, 3 номер.

П.Дэлгэрнар: Манай бол гол нь төхөөрөмжтэй зүй холбоотой зүйл Пүрэвдорж гишүүнийг хэлсэнд их баярлалаа. Таны хэлсэн үг бол манай төхөөрөмжийг бол олон түмэнд итгүүлэх, итгэлцэл олоход итгэхэд их дөхөмтэй. Манайхыг дэмжиж хэлсэнд танд их баярлалаа.

Тэгээд би тэр түрүүн тэр програмтай холбоотой асуудлаар бид нар Dominion voting компанид тэр лиценз дууссан гэж яриад байгаа чинь тэр программынхаа лицензийг төлөхийг л хэлээд байгаа юм. Тэгээд бид нар бол яг цаг хугацаанд нь бүгдийг нь тэр программынхаа лицензийг бол байнга төлж яваа. Тэгээд тэр нь бол бүгд баримтаараа байгаа. Бас өнгөрсөн жил гомдол гаргасан хүмүүст бид нар бүр баримтаар нь үзүүлж, шалгуулсан ийм асуудал байгаа.

Г.Ганболд: 2 номер.

Д.Дэлгэрсайхан: Дэлгэрсайхан асуултад хариулъя. Эхлээд Учрал гишүүний хувьд бол хаягийн шилжилт хөдөлгөөнөө хийгээгүй юм байна лээ. Тэгээд хийгээгүй учраас өөр дээр нь тийм олон хүн гараад ирсэн. Түүнээс биш иргэний улсын бүртгэл дээр олон хүүхэдтэй гээд тэр асуудлуудыг мэдээллийг нь бид нар шалгасан л даа.

2 дугаар асуудал дээр энэ сонгогчдын нэрийн жагсаалтын талаар ярьж байна. Нэрийн жагсаалт бол миний түрүүний хэлдэг хэд хэдэн байгууллага гэрчилгээжүүлж оролцохоос гадна бүх хэсгийн хороод дээрээ жагсаалтаараа цаасаар очдог, энэ хадгалагддаг. Тухайн намын болоод ажиглагчид нь байдаг юм уу эсвэл СЕХ-ны ажилтнууд улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнаар дамжуулаад нэрийн жагсаалттай танилцах боломж бас байдаг.

Өөрөөр хэлбэл зөвхөн энэ мэдээллийн сан дээр байж байгаа I хүснэгт биш энэ хүснэгт өөрөө давхар цаасаараа байдаг. Энэ цаастайгаа бас тулгагдаж гардаг ийм онцлогтой. Тэгэхээр зөвхөн энэ бол зүгээр I алгоритм программаар бас шалгагдаад байхгүй. Цаасны асуудал давхар байдаг. Өнөөдрийн яригдаж байгаа I асуудал бас энэ мэдээллийг хэр өгч байна энэтэй холбоотой асуудал яах аргагүй үнэн. Одоо

яг өнөөдөр БЗД-ийн 31 дүгээр хороо 1 дүгээр гудамжны 19 тоот дээр 76 иргэн байна жишээ нь. Энэ иргэн бол Загдаа гуайн Зөв амьдрах ухааных л даа. Тэгэхээр энэ сонгогчдын нэрийн жагсаалт дээр энэ бол Зөв амьдрах ухааны хүмүүсээ гэж гардаггүй, зөвхөн жагсаалт харагддаг.

Бид нарын хувьд яагаад энийг мэдээлдэггүй вэ гэхээрээ энд байж байгаа Батболд, Дорж, Цэцэгээ бол Зөв амьдрах ухаанд амьдарч байгаа хүн гэдэг ингэж гаргаж болохгүй. Өөрөөр хэлбэл улсын бүртгэлийн байгууллага 1 талаасаа иргэдийнхээ мэдээллийг хадгалдаг, хамгаалдаг ийм бас чиг үүрэг нь давхар байдаг учраас ийм байдлаар энэ мэдээллийг бид нар гаргаад зөвхөн сонгуульд зориулсан тухайн өдрүүдэд маш олон хүний мэдээллийг энэ бол ийм амьдрах ухааны, энэ бол ингээд ингэчихсэн гэдэг бас гаргах энэ бололцоо байдаггүй гэдгийг та бүхэн бас ойлгоосой гэж хүсэж байна.

Энэ жишээ бол түрүүн Магнайсүрэн даргын хэлдэг бид нар шинэ хаяг хийсэн ч тухайн асрамжийн газар буюу тэр хаяг дээр тоот дээр энэ хүмүүс өнөөдөр бол байсаар л бас байгаа. Тийм учраас бид нар тэр болгон дээр нь бүртгэл яг ийм хүн байна шүү, энэ бол ийм учиртай гэж бас мэдээлэл бас гаргаад байдаггүй, энэ хязгаартай мэдээлэл байдаг юм шүү гэдгийг бас тайлбар хэлэх гэсэн юм.

Г.Ганболд: Туваан гишүүн асуулт асууя.

Ц.Туваан: Тэгээд өнөөдөр энэ сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой бас энэ дэд хороо хуралдаж байна. Тэгээд энэ дээр бас нэг хэд 3 асуулт байна. Бас хэлэх үг байна. Ер нь бол энэ сонгууль гэдэг энэ арга хэмжээг УБЕГ явуулдаг юм уу, СЕХ явуулдаг юм уу гэж асуухаар хэмжээнд хүртэл энэ асуудал явагдаж байгаа шүү дээ. УБЕГ дээр ингээд маш олон юунууд оччихсон, функцүүд оччихсон. Тэгээд эцсийн

хариуцлага сонгуультай холбоотой янз бүрийн маргаан гараад ирэхээр эцсийн хариуцлага хэн хүлээх вэ гэдгээс эхсүүлээд ингээд асуудлууд байдаг.

Тэгэхээр түрүүн бас Цогтгэрэл гишүүн асуугаад байна л даа. Энэ сонгогчийн юу шүү дээ тэр сонгуулийн юу хэсэг хэсгээр нь ингээд нэрийг нь гаргаад өгчихнө гэж байгаа юм. Тэгээд offline гэж байгаа юм. Тэгээд тэрэн дээр чинь би Туваан одоо бүр хөдөө суманд ч арай гайгүй л байх, ядаж хүнээ таньдаг. Аймаг дээр хагас таньдаг, хотод бол танихгүй. Тэгээд ингээд тойроод явчихна шүү дээ. Танай гаргаж өгсөн хэсэг дотор Тувааныг хэд 50 ч биччихсэн юм уу яаж мэдэх юм. Энэ хаана яаж хянагддаг юм бэ? Энийг яагаад ер нь заавал ингэж хэсэгчлээд байдаг юм бэ?

Би жишээлбэл 1 хотод байгаа Хаан банкны АТМ-аас 1 мөнгө аваад, Төв аймагт очоод 1 мөнгө авахад миний дансны мөнгө хасагдаж л таардаг биз дээ. Тэгээд та нар энэ ганцхан юм гаргаж чадахгүй байж юун ийм ИМонголиа яриад байгаа юм. Ер нь боль л доо та нар. Дээр үеийн ямар 90 оны юм ярьж байгаа биш, нэг тийм сонгогчдын нэрсийн жагсаалтыг гаргахгүй гээд. Тэгээд хар машин сонгогчдын тэр өгсөн саналын хуудас тоолуулаад яах юм ер нь, таарч л таарна шүү дээ тэр чинь. Тэр чинь гаргаад л ирж байгаа юм чинь тэрэн дээр чинь таарна. Тэгээд тэр цаад талын нэгдсэн нэрсийн жагсаалт руу тулгаж байгаа юм огт байхгүй. Тэнд хэд байгааг хэн мэдэж байгаа юм ер нь. Тэгээд бүгдийг нь ярихаар Тагнуулын ерөнхий газар гээд ингээд нууцтай хамааралтай юм руу чихээд хаячихдаг.

Одоо бол энэ хууль дээр энэ асуудлаа болиорой. Та нар УБЕГ бол хүний зүв зүгээр байж байгаа тамгыг байхгүй гээд өөр хүнд хийж өгчхөөд, ичихгүй, улайхгүй сууж байдаг улсууд бол энэ дайны юмыг бол хөнгөхөн хийнэ. Тэгээд 1 сайхан хуулийн хамгаалалттай. Одоо энэ хууль дээр бол энэ хэрэв та нар үнэхээр энэ

сонгуулийг бас төрийн цалин авч байгаа үүрэг хүлээснийхээ хувиар будилуулахгүй явуулъя гэж байгаа бол энэ нэгдсэн сан руу шалгадаг асуудлыг нь шийдэж байж ороорой. Үгүй ээ, та нарын луйварт энэ Монголын ард түмний энэ санал хаашаа яаж явж байгаа энэ тэр гэдэг чинь бол мэдэж байгаа шүү дээ.

Тэгээд яаж тэр жишээлбэл иргэн давхар тоолж байна. Тэр чинь сантай манайхан ингээд заримдаа та хэд бол төөрөгдүүлээд ирчихсэн. Яасан гэхээр нөгөө хар машин саналын хуудас 2 нь таарах л юм яриад байгаа юм. Үгүй шүү дээ. Энэ чинь тэр нэгдсэн сангийн мэдээлэл дотор дахиж орж уу, үгүй юу гэдэг чинь бас давхар хянагдах ёстой байхгүй юу. Ажиглагч хүн ийм л юм хийх ёстой. Тэрнээс биш ямар тэр киноны эффект үзүүлдэг машинтай тэрийг тааруулчихаад таарч байлаа гэж ярих бол өрөөсгөл.

Энэ илтгэл дээр хүртэл энэ сая нөгөө хүүхдийн мөнгөтэй холбоотой энэ баахан цахим юунууд мөргөлдөөд л, нөгөө цахим үндэстэн ИМонголиа ээ гэгээн гээд байсан чинь хаана байгаа юм бэ? Яг энэ шиг юм сонгууль дээр гарахгүй гэх баталгаа хаана байгаа юм бэ? Би энийг л яриад байгаа юм. Тэгэхээр одоо та нар наад нэгдсэн систем рүү хийж шалга. Тэгэхгүй танай наад хэсэгчлээд хийгээд өгчихсөн offline 2000 нэр дотор чинь.../минут дуусав/

Г.Ганболд: 2 номерын микрофон өгье. Дараа нь тодруулаад асуучих уу, 2-ыг өгье.

Д.Дэлгэрсайхан: Дэлгэрсайхан асуултад хариулъя. Би тагнуул байдаг юм уу, СЕХ, бусад оролцож байгаа энэ байгууллагуудыг хасаад маш энгийнээр тайлбарлахыг хичээе. Өөрөөр хэлбэл сонгуулийн нэрийн жагсаалт тэр offline байдлаар бүх хэсгүүдэд очдог. Очоод Монгол Улс хамгийн мэдэгдэж байгаа зүйл нь юу байдаг вэ гэхээрээ сонгогч хэдэн 2.2 сая сонгогчтой гэдэг нь тов

тодорхой байж байгаа. Тэгэхээр хэрэв тухайн хэсэг дээр Дэлгэрсайханы байдаг юм уу, Батболд Доржцэцэгийг нэмээд байдаг бол бүх хөлийн дүнгүүдийг нэмээд үзэхэд л энэ тоо мөргөж байгаа, хамгийн энгийн жишээ. Өөрөөр хэлбэл Дэлгэрсайханыг 10 хувилчихдаг бол өгч байгаа сонгогчдын тоо 10-аар нэмэгдэнэ. 20 хувилбал 20-иор нэмэгдэнэ. Бүх орон даяар тэгж байгаа бол 200, 300-гаар дор хаяж ингэж нэмэгдэнэ.

Миний ойлгуулах гээд чармайгаад байгаа зүйл юу юм бэ гэхээрээ энэ яг өнөөдрийн түвшинд улсын бүртгэлийн байгууллага таны хэлж байгаагаар ИМонгол байдаг юм уу, нэгдсэн сангаар зохион байгуулах потенциал байгаа. Нэгдсэн байдлаар. Харин нэгдсэн байдлаар зохион байгуулахад өнөөдөр яг хууль, эрх зүйн орчин болоод энэ нөгөө хардлагын асуудал нь илүү ч бараг нэмэгдэж магадгүй ийм асуудлууд байж байгаа. Яагаад гэвэл улсын бүртгэлийн мэдээллийн санг энэ бол тастаж аваад хэрэглэдэг асуудал.

Улсын бүртгэлийн байгууллагын 330 сумын сүлжээг ашигладаггүй. Хэсгийн хороод дээр яг өнөөдөр техник хангамж, программ хангамж нэгтгэгдсэн мэдээллийн сангийн түвшинд нь бид нар энэ дэд бүтцээ арай ч шийдэж амжаагүй байгаа юм л даа. Тэгэхээр бид нар яг тэр тасалж өгсөн хэсгээ холбогдох байгууллагуудад хүлээж өгдөг ийм бүүр процесстой. Хүлээлгээд өгчихдөг, хүлээгээд авсан газар нь тэр хүлээж авсан компьютер дээрээ хэдэн хүн байна бүгдийг нь тоолоод, хөлийн дунг нь хараад, хоорондоо ингээд нэмээд үзэх энэ бололцоо нь бас байдаг л даа. Тэгэхээр offline гэж би яриад байгаа нь үнэхээр техник технологийн дээрээс нь тэр аюулгүй байдлынхаа асуудал дээр л өнөөдөр шийдэж байгаа шийдлийн хамгийн сайн нь л энэ гэж харж байгаа юм.

Харин түрүүн таны хэлээд байгаагаар ямар нэгэн байдлаар бид нар

нэгдсэн байдлаар зохион байгуулбал Монгол Улсад 2200-гаад хэсэг байлаа гэж үзвэл 2200 хэсэг нь дэд бүтэц нь дээд зэргээр хөгжчихсөн, нэгдсэн сантайгаа уялдаа холбоотой ажиллах ийм дэд бүтэц зардлыг л бас нэхэх ийм л шаардлага л бас гарна л даа. Тэгэхээр би яг тэнд ажиллаж байгаа хүмүүс бол зөвхөн улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан биш, намуудын ажиглагч нараас авхуулаад, тэнд ажиллах эрх бүхий СЕХ ахлагч нь, итгэмжлэгдсэн ажилтнуудаар ядаж л нийт жагсаалтынхаа тоог авчих ийм бас бололцоо бас байгаа л даа.

Г.Ганболд: Туваан гишүүн тодруулъя.

Ц.Туваан: Тэр техникийн боломж нь байгаа гээд хэлчих шиг боллоо. Хууль, эрх зүйн орчноо шийдье. Тэр зүгээр би түрүүн мөнгөөр жишиж хэллээ шүү дээ. Тэр хэсгийн хороон дээр чинь хүн очоод тэр юугаа таниулаад, хурууны хээгээ таниулаад гаргаж байгаа тэр таньж гарч ирж байгаа юмаа л нэгдсэн сангаас гаргачих л даа. Заавал тэрийг тэгж хэсэгчилж яагаад хүнд хар сэжиг төрүүлж ингээд хувааж өгөөд байгаа юм бэ? Хэрэв үнэн явуулах гээд л байгаа юм бол тэгээд тийм ажиллагаа руугаа л та хэд яв л даа. Тэр зардал ер нь ямар хамаатай юм. Тэртээ тэргүй л гардаг шүү дээ. Хэдэн төгрөгийн зардлын асуудал яриад байгаа юм бэ энэ дээр?

Дээрээс нь энэ Ерөнхийлөгчийн сонгуульд тэр гадаадад байгаа хүмүүсийн чинь тоо нь хүртэл энэ илтгэл дээрээ хүртэл ядаж зөрүүтэй байх юм. Тэгээд энэ юм чинь 1 байж ядаж болдоггүй юм уу? Тэгээд энэ дээр хэдэн хувийн санал Ерөнхийлөгчийн сонгууль дээр санал өгсөн юм. Хамгийн сүүлийнх дээр. Нийт.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номер.

П.Дэлгэрнар: Ерөнхийлөгчийн 21 оны хамгийн сүүлийн Ерөнхийлөгчийн

сонгуулийн үеэр гадаадад байгаа иргэдээс сонгуулийн санал өгөхөөр 7398 хүн саналаа өгөхөөр бүртгүүлсэн эхлээд. Тэгээд энэ эцсийн байдлаар сонгогчдын нэрсийн жагсаалт энд бүртгүүлсэн 7398 хүнээс сонгогчдын нэрсийн жагсаалтад 7394 хүн үлдэж баталгаажигдсан. Тэгээд тэрнээс 5568 хүн саналаа өгсөн. Нийт бүртгүүлсэн хүмүүсийн 75.3 хувь нь саналаа өгсөн ийм дүнтэй байгаа. Нийт байгаа гадаадад байгаа иргэдийг бол иргэдийн ийм байгаа юм. Тэр тэр үеийн тооцооллоор бол яасан гэхээр 122.../минут дуусав/

Г.Ганболд: 3 номерыг сунгая.

П.Дэлгэрнар: Нийт гадаадад ажиллаж, амьдарч байгаа тэр үеийн статистик тоо бол 122300. Энэнээс бол сонгуулийн насны 90-ээд мянган хүн байсан. Энэнээс 5563 гэх юм бол 5-6 хувь орчим, 6, 7 хувь орчим л ийм л болж байгаа юм.

Г.Ганболд: Гишүүд асуулт асууж, санал хэллээ. Тэгээд би түрүүн хэлсэн. Ер нь бол бид нарын нөгөө түр хороо нь дэд хорооны зорилго бол энэ Сонгуулийн хуультай холбогдуулаад ирэх онд сонгууль болох гэж байгаатай холбогдуулж мөн урьдчилсан бид нар бас нөгөө хүндрэлүүдээ эртхэн шиг төр засгийн байгууллагуудад хүргэх ёстой. Их Хурлын удирдлагуудад, ТББХ-нд бид нар санал, дүгнэлтээ хүргүүлэх ёстой. Тэгээд энэ хүрээнд бол яах вэ ер нь бол хэд хэдэн асуудал сая гишүүд яг ярьж байна л даа. Байнга л сонгууль болгоны дараа ярьдаг.

Хар машинд бол би, би ч гэсэн бас яг Пүрэвдорж гишүүнтэй адилхан итгэдэг. Олон удаа сонгуульд орж, энэ орон нутагт бас удирдаж, дараа нь хяналтын тооллого хийж тулгаж үзсэн хүний хувьд бол би бол мөнхийн итгэдэг. Энийг бол би сканер л гэж боддог юм л даа. Тэр агуулгаараа бол манайхан нөгөө сонгуулийн дүн гарчихаар тэгээд хаягчаад явцагачихдаг байхгүй юу. Дараа нь тэр зарим 1 хяналтын тооллогуудаа

хэвлэл мэдээллээр ингээд нээлттэй харуулаад, иргэдийн эргэлзээг тайлахад л ерөөсөө төр засаг юу ч хийдэггүй. Дун гараад л бүгдээрээ ингээд л ялагдсан нь гутраад л, ялсан нь баярлаад алга болцгоочихдог байхгүй юу.

Тэрний ард ерөөсөө бид нарын хийх ёстой юм бол энэ иргэдэд тэр сонголтын итгэл үнэмшлийг төрүүлэхийн тулд тэр хяналтын тооллогууд дээр бүр яг нээлттэйгээр хэдэн тойрог дээр ингээд хийж байж, иргэд ялагдсан нь ч тэр, ялсан нь ч тэр итгэл үнэмшилтэй болох тухай асуудал ерөөсөө хийдэггүйтэй холбоотой асуудал байдаг гэж боддог би бол. Энэ агуулгаараа бол одоо хэдүүлээ энэ сонгууль нэгэнт болох нь тодорхой. Тэгээд энэ агуулгаараа сая Дэлгэрнаран даргын хэлсэн энэ хар машины баталгаажилт чинь бол дуусчих юм байна. Таны хэлж байгаа мэдээллээр бол ингээд ирэх жил бид нар хар машинаар санал авчих юм бол дараа нь нөгөө сонгууль чинь баталгаажихгүй юм байна. Дараа нь ялагдсан хүн наадах чинь хугацаа дуусчихсан программаар санал хураасан гээд шүүхэд өгөх юм бол унах юм байна шүү дээ ер нь.

Тэгээд энэ асуудлыг бид нар энэ Байнгын хороо, Их Хурал дээр бид нар хэлэх ёстой. Сонгуулийн хуулиас өмнө. Тэгж байж энэ машинаа баталгаажуулах юм уу эсвэл энэ хар машин гэдэг юм байхгүй бол бид нар гар тооллого руу орох уу гэдэг асуудлаа эртхэн шийдэх ёстой. Тэгж байж энэ нийгмийн эргэлзээнүүдийг ер нь бол цаашдаа хэдүүлээ хангах зайлшгүй шаардлага байна. Би бүртгэлийн даргад сая Пүрэвдорж гишүүний тэр эргэлзээд байгаа хүний нэр хэлээд яах вэ. СХД-ийн тэр тодорхой кэйс дээр та нар ажиллаад, ер нь бол нэг энэ хүн эргэлзээтэй байна гэдэг нийгэм эргэлзээтэй байгаагийн шинж шүү дээ. Тэгэхээр зэрэг бас Их Хурлын гишүүд нь өөрсдөө бид нар эргэлзээгээ тайлж байж энэ юм чинь явах ёстой байхгүй юу. Яг саяын бэлэн кэйс дээр та нэг ажиллаад,

Пүрэвдорж гишүүнд надаар дамжуулаад ч юм уу, 1 дүгнэлт хийгээд өгөөч.

Магадгүй Сонгуулийн хууль хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын чуулган дээр ч юм уу асуудал гарах юм бол бид нар чинь тайлбартай сууж баймаар байна шүү дээ. Тайлбар хэлж чадахгүй ингээд бүгдээрээ ингээд дүмбийгээд гөлийгөөд суугаад байх юм бол энэ өөрөө эргэлзээтэй асуудал болох нь.

Хаягжилтын асуудал чухал. Тийм учраас Магнайсүрэн дарга энэ хаягжилтын асуудлуудыг, энэ улсын бүртгэлийнхэн энэ хүүхдийн мөнгөтэй холбогдуулаад ер нь сонгуулиас өмнө энэ нэг бүртгэлийнхээ эмх замбараагүй байдлыг ер нь нэг жаахан цэгцлэхгүй бол ерөөсөө нийгмээрээ дүүрэн эргэлзээтэй. Хөдөө явж байхад л энэ хүүхдийн мөнгөтэй холбоотой энэ янз бүрийн юмнууд энэ өмнөх сонгуулийн үеийн нөгөө царцаа чинь одоогоороо арилаагүй. Энэнээсээ болоод зарим нь илүү болчихсон, зарим нь дутуу болсон. Яг нарийн ярих юм бол сонгуулийн үед шилжүүлсэн хүмүүс л юм байна лээ шүү дээ ер нь бол нарийн яривал. Тэрийгээ эргэж бүртгээгүй л юмнууд л ажиглагдаж байна лээ шүү дээ. Би зөндөө олон кэйс дээр бас гишүүний хувьд хүмүүс өргөдөл өгөхөөр нь ажиллаж үзсэн.

Тэгэхээр энэ болгоныг нэг хэдүүлээ цэгцлээд, тэгээд энэ сонгуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд та хэдийн өнөөдрийн асуудлыг сонсож байгаа нь саналуудаа нэг надад өгөөдхөөч. Гадаадын иргэдийн саналыг бүрэн авахад хэдий хэмжээний хөрөнгө мөнгө хэрэгтэй юм бэ гэдгийг нэг гаргаад өгөөч. Хэдэн хүн орох боломжтой юм, тэрийг саналыг нь авахад ямар хувилбар байгаа юм, бодитойгоор биетээр ингээд саналын хайрцагар авах юм бол хэдэн төгрөг гарах юм. Тэгэхээр энийг чинь бид нар ингээд энэ холбогдох байгууллагуудад өгч, ядаж энэ ирэх оны төсвийн үеийн хүрээнд энэ хууль хэлэлцэхэд яримаар байна. Хэдэн хүн сонгуульд орох юм, бие даасан тойрог

байх юм уу, эсвэл пропорциональ дээр нь зөвхөн санал авах юм уу, ямар хэмжээний хөрөнгө мөнгө хэрэгтэй юм гэдгийг нэг шийдчих хэрэгтэй. Санал өгөх хэрэгтэй.

Энэ хар машин гэдэг юмыг цааш нь нөгөө 1 software-ийг нь баталгаажуулахын тулд хэдэн төгрөг бас хэрэгтэй юм бэ гэдгийгээ яаралтай гаргаж өгмөөр байна саналаа. Тэгээд би энийг нөгөө дэд хорооны хувьд ингээд Их Хурал руу хурлаар хэлэлцээд ийм асуудлыг нэн яаралтай шийдэх шаардлага байна гэдгийг бид нар энэ Сонгуулийн хуулийн өмнө зэрэгцүүлээд өгөх нь зүйтэй гэж ингэж бодож байна л даа. Тэгээд энэ асуудлуудыг та хэд маань нэг жоохон цэгцэд нь оруулаад, тэгээд энэ 3 байгууллага л байна. Хаягжилтын асуудал шийдэхэд ямар проблем байгаа юм, улсын бүртгэлийнхний хувьд бас зөндөө асуудлууд бий л дээ. Тэгээд энийг нэг жаахан цэгцлэхийн тулд яах юм. СЕХ ер нь бол энэ сонгуулийг будилаангүй явуулахад тав, гурав төгрөг шийдэх зайлиггүй шаардлагууд байна гэх юм бол энэ саналуудаа нэг, өнөөдөр бол сонсчихлоо. Проблем ийм байгаа.

Ер нь бол энэ асуудлыг шийдэх ёстой юмыг сонсчихлоо. Магадгүй дараагийн хурлаар шууд тодорхой төсөв мөнгөтэй холбоотой юмнуудыг хэлэлцээд, тэгээд нэг гишүүдээрээ шийдвэр гаргуулаад, Их

Хурал руу өргөн барья гэсэн ийм бодол байна. Тэгээд энэ хүрээнд та бүхэн маань нэг жаахан ажиллаад, тэгээд саналуудаа боловсруулаад ирүүлчих. Тэгээд энэ асуудлыг ингээд шийдье гэж ингэж бодож байна.

1.40 цаг

Өнөөдрийн хуралдаанд оролцсон гишүүдэд баярлалаа. Тэгээд хуралдааны ажиллагаа хаасныг мэдэгдье. Баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА